



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Б.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

**МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,
Утас: 264216, Факс: 264460,
E-mail: info@csc.gov.mn

2018.09.17 № 965
танай _____-ны № _____-т


2018 оны 08 дугаар сарын 17-ны
өдрийн 36 тоот асуулгын хариу

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн хүрээнд төрийн албаны төв байгууллага хараат бус байдлаар ажиллаж буй эсэх, Зөвлөл нь төрийн албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх талаар авч хэрэгжүүлж байгаа ажил, Төрийн албаны хууль зөрчсөн зөрчлийг арилгуулах талаар авч буй арга хэмжээ, хууль дээдлэх зарчмыг гажуудуулдаг байдал аль төвшинд байгаа, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах ажиллагааны явц, Төрийн албаны тухай хуулиар хориглогдсон заалтууд зөрчигдөж буй эсэх, төрийн албаны хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг бодитойгоор тодорхойлж төрийн байгууллага, албан тушаалтнуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж буй байдал, ажлаас үндэслэлгүйгээр халагдсан албан хаагчдыг албан тушаалд нь эгүүлэн томилсон шүүхийн шийдвэр бүрэн биелэгддэг эсэх, албан хаагчдын зүгээс гэмт хэрэг үйлдэж, шүүхээр буруутай нь тогтоогддог байдлын өсөлт, бууралт, улсад учруулсан хохирлын хэмжээ зэрэг асуудлаар тавьсан асуулгын хариуг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт ~~77~~ хуудастай.


Хүндэтгэсэн,

ДАРГА



Б.ЦОГОО

Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 9 дүгээр сарын 17-ний өдрийн 965 тоот албан бичгийн дугаар хавсралт



АСУУЛГЫН ХАРИУ

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангаас Төрийн албаны зөвлөлийн бие даасан хараат бус байдал, шударга ёсны зарчим болон Төрийн албаны тухай хуулийн заалтын хэрэгжилт, төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн талаарх мэргэжил арга зүйн дэмжлэг, төрийн албан хаагчийг хууль бусаар халсныг тогтоосон шүүхийн шийдвэрийн хэрэгжилт, гэмт хэрэг үйлдсэн болон буруу шийдвэр гаргасны улмаас төрд учруулсан хохирлын хэмжээг шүүхээр тогтоосон байдлын талаар тавьсан асуулгад дараах хариултыг хүргэж байна байна. Үүнд

Нэг. Төрийн албаны зөвлөлийн бие даасан, хараат бус байдлын талаар

Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар Төрийн албаны зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд дарга, 6 гишүүний бүрэлдэхүүнтэй, хараат бус бие даасан байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа жил бүр Улсын Их Хуралд тайлагнан ажиллаж, тодорхой чиглэл аван ажиллаж ирлээ.

Төрийн албаны зөвлөл нь хараат бус, бие даасан байдлаа ханган ажиллаж өөрийн чиг үүрэгт хамаарах нөөц боломжоо бүрэн дайчлан ажиллаж ирлээ.

Гэвч төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаанд дараах нөхцөл байдал ямар нэгэн хэлбэрээр хүндрэл учруулж байгааг хэлэх нь зүйтэй. Үүнд

- Байгууллагын бүтэц, зохион байгуулалт:

Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.13 дахь хэсэгт “Зөвлөл нь орон тооны болон орон тооны бус салбар зөвлөл, ажлын албатай байна. Ажлын албаны даргыг Төрийн албаны зөвлөл томилж, чөлөөлнө. Орон тооны салбар зөвлөл болон ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийг Улсын Их Хурал батална” гэж заасан байдаг.

Дээрх заалтын дагуу Улсын Их Хурлын 2002 оны 70 дугаар тогтоолоор Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны бүтэц, орон тоог Ажлын албаны дарга-1, ахлах референт-5, референт-3, шинжээч-2, нягтлан бодогч-эдийн засагч-1, бичиг хэрэг, архивын эрхлэгч-бичээч-1, даргын туслах-1, нийт 14 ажилтантай байхаар баталсан.

Өнгөрсөн 16 жилийн хугацаанд Зөвлөлийн бүтэц орон тоонд ямар нэгэн өөрчлөлт ороогүй бөгөөд энэ хугацаанд төрийн албан хаагчдын тоо 52000 мянгаар нэмгэдсэн байна

Ажлын алба өнөөдрийг хүртэл зохион байгуулалтын бүтцийн нэгжгүй, 14 ажилтантайгаар Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлд бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн төлөө ажилладаг, тухайлбал, ажлын албаны нэг ажилтан гэхэд төрийн албаны шалгалт, төрийн жинхэнэ албан хаагчийн нөөц болон хяналт шалгалтыг улсын хэмжээнд хариуцаж байгаа нь Зөвлөлийн хуулиар хүлээсэн чиг

үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэлтэй байгаагаас гадна бие даасан байдлын зохион байгуулалтын баталгаа болж чадахгүй байна.

- Байгууллагын төсөв, санхүү, ажиллах нөхцөл

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуульд Төрийн албаны зөвлөлийн төсвийг 730.8 сая төгрөгөөр баталсан байна.

Зөвлөлийн төсөв, цалингийн сан, гишүүдийн цалингийн хэмжээ анх 1995 онд батлагдсан. Өнгөрсөн хугацаанд зөвлөлийн төсвийг улсын төсвийн өсөлттэй уялдуулан батлуулж ирсэн.

Мэргэшлийн шалгалт зохион байгуулах, орон нутагт томилолтоор ажиллах, маргаан хянан шийдвэрлэх, судалгаа шинжилгээний үйл ажиллагаа явуулах төсөв дутагдалтай байдгаас гадна үйл ажиллагаагаа явуулах өөрийн гэсэн байргүй зэрэг нь мөн бие даасан байдлын баталгаа хангагдахгүй байгаагийн нэг илрэл гэж үзэж байна.

- Хуульд заасан маргааныг хянан шийдвэрлэх, хяналт шалгалт үйл ажиллагаа:

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн хүрээнд гүйцэтгэж байна.

Зөвлөл нь маргаан хянан шийдвэрлэх, хяналт шалгалт явуулах чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадахгүй байгаа юм. Энэхүү байдал нь зөвлөлийн ажлын албаны бүтэц оновчгүй, төсвийн хүрэлцээгүй байдалтай холбоотой юм. Зөвхөн төрийн албан хаагчийг халсан, чөлөөлсөн маргааныг шийдвэрлэхийн тулд нөхцөл байдлыг зөв тогтоох, сонсох ажиллагаа явуулах зэрэг процессын ажиллагаа хуулийн дагуу хийгдсэн эсэх, шийдвэрийн хууль зүйн үндэслэл зөв эсэхэд дүн шинжилгээ хийх, холбогдох этгээдээс тайлбар авахад нэлээдгүй хугацаа, хүн хүч, ур чадвар, зардал шаардагдагаас гадна энэхүү асуудлыг улсын хэмжээнд бүхэлд нь Ажлын албаны ганцхан ажилтан хариуцаж байгаа нь учир дутагдалтай байна.

Мөн сонгон шалгаруулалт, мэргэшлийн шалгалт, гомдол, маргааныг хянан шийдвэрлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусгагддаггүй.

Төрийн албаны зөвлөлд ирсэн гомдол маргааны 90 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагчдийн эрх зөрчигдсөнтэй холбоотой байдаг бөгөөд энэ Зөвлөлийн маргаан хянан шийдвэрлэх хүрээнд хамаардаггүй бөгөөд хөдөлмөрийн гэрээ, контрактаар зохицуулагддаг тул Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ихэвчлэн шүүх рүү шилжигддэг.

Төрийн албан хаагчдаас сүүлийн 6 жилийн дотор ажлаас үндэслэлгүйгээр халсан тухай 778, төрийн жинхэнэ албаны сонгон шалгаруулалт, дүгнэлт, нөөц томилгоотой холбоотой 413, мэргэшлийн шалгалт, шалгуур, дүгнэлт нөөц, томилгоотой холбоотой 460, төрийн үйлчилгээний албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалттай холбогдолтой 103, тэтгэвэр тэтгэмж, цалин хөлс, шагнал урамшуулалттай холбоотой 112, албан тушаал үндэслэлгүйгээр бууруулсан тухай

116, бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөн тухай 288, албан тушаалд томилохгүй байгаа тухай 53, ажилд эгүүлэн тогтоосон тухай шүүхий шийдвэр биелүүлэхгүй байгаа тухай 13, томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгох тухай 66 гомдлыг Төрийн албаны зөвлөлд ирүүлжээ.

Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлоор маргааныг хянан шийдвэрлэдэг. Маргаан хянан шийдвэрлэсэн шийдвэр, түүний хэрэгжилтийн байдлыг дараахь хүснэгтээс харж болно.

д/д	Он	Нийт маргаан	Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг		Албан тушаалд буцаан томилогдсон	Албан тушаалд буцаан томилогдоогүй
			Хүчингүй болгон шийдвэрлэсэн	хууль зүйн үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн		
1	2004	14	9	5	9	5
2	2005	23	18	5	13	10
3	2006	21	16	5	9	12
4	2007	18	14	4	11	7
5	2008	9	8	1	5	4
6	2009	26	21	5	21	5
7	2010	9	6	3	8	1
8	2011	18	12	6	17	1
9	2012	16	11	5	10	6
10	2013	6	6		4	2
11	2014	14	14		4	10
12	2015	8	8		7	1
14	2016	5	5	-	5	
15	2017	4	4	1	-	1
НИЙТ		191	147	40	123	65
			76.9%	20.9%	64.3%	34.0%

Жич: Судалгааг сүүлийн 13 жилийн байдлаар гаргав.

Судалгаанд 2004-2017 оны хооронд Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хянан шийдвэрлэсэн маргаан хамаарч байгаа бөгөөд маргаан хянан шийдвэрлэгдсэн байдлыг 4-5 жилийн дунджаар авч үзвэл 2004-2007 онд 19, 2008-2011 онд 15.5, 2012-2016 онд 9.8 байна.

Хоёр.Төрийн албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх талаар авсан бодитой арга хэмжээний талаар:

Зөвлөл нь төрийн албаны үйл ажиллагааг зөв цэгцтэй, цэвэр ариун байх үндэс болох шударга ёсыг зарчмыг хэрэгжүүлж, ялангуяа төрийн албанд ах дүүрхэх, танил тал харах, хээл хахууль, шан харамж авах, албан тушаалаа ашиглах, нутаграх, хүнд суртал чирэгдэл гаргуулахгүй байх, хууль бус томилгоо, хөдөлгөөнийг таслан зогсооход үйл ажиллагаагаа чиглүүлж ирлээ.

Гэвч ээлжит сонгууль болгоны дараа Улсын Их Хурлаар Засгийн газрын бүтцийг өөрчилсөн хууль баталдаг, Засгийн газар өөрчлөгдөх бүрд Засгийн газрын тогтоолоор¹ яам, агентлагийн бүтэц, орон тоог өөрчилдөг төдийгүй аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, аймаг, нийслэлийн Засаг даргын харьяа агентлагуудын бүтцийг өөрчилсөөр иржээ. Дээрх өөрчлөлтийг хийхдээ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилттойгоо уялдуулж байгаа мэт боловч шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, тооцоо, чиг үүргийн шинжилгээнд үндэслэдэггүй, төрийн албаны төв болон холбогдох бусад байгууллагын санал авдаггүй, орон тоо бууруулах, төсвийн ачааллыг багасгах, хэмнэх зарчмыг баримталдаггүй, зөвхөн яамдыг салгах, нийлүүлэх, нэршлийг солих, агентлагийн харьяаллыг өөрчлөх зэргээр төрийн захиргааны байгууллагуудын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг баталсан байдаг.

Дээрх бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт нь төрийн албаны хүний нөөцийн бодлого тогтворгүй, төрийн албан хаагчдын албан тушаал, ажлын байр баталгаагүй, улс төрийн нөлөөлөлд автагдаж, бүх шатны төрийн байгууллагын үйл ажиллагааны эрч хүч, үр нөлөөг бууруулж, улмаар Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх дотоод аюулгүй байдлын үндэс суларч болзошгүй хэмжээнд хүргэж байгаа талаар Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайланд тухай бүр тусгаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар саналаа хүргүүлж, Улсын Их Хурлын гишүүдийн сонорт хүргэсэн гэж манай Зөвлөл үздэг.

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлд төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно гэж заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах тусгай шаардлагын төслийг Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 1048 тоот албан бичгээр, 2012 оны 966 тоот албан бичгээр Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлсэн боловч өнөөдрийг хүртэл батлаагүй. Иймээс төрийн албаны удирдах ажилтны томилгоо улс төрөөс хараат, мерит зарчим хэрэгжихгүй байсаар байна. Гэхдээ 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөх Төрийн албаны тухай хуульд “мерит зарчим”, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хуульчилж өгсөн дэвшилттэй зүйл болсон гэж үзэж байна.

Төрийн албаны зөвлөл нь 1995 оноос төрийн байгууллагуудын захиалгын дагуу төрийн албанд анх орох иргэний болон удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг шударга ёс, ил тод, тэгш байх зарчмын хүрээнд зохион байгуулж ирлээ. Сонгон шалгаруулалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл бүхий зарыг Зөвлөлийн www.csc.gov.mn гэсэн цахим хуудсанд шалгалт эхлэхээс 21-ээс доошгүй хоногийн өмнө байршуулж, мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэхээс гадна сонгон шалгаруулалтыг ил тод, шуурхай зохион байгуулах, үнэлгээг бодитой, хардлага, сэрдлэггүй байлгах үүднээс “НҮБ-ын Монгол Улсад шударга ёс, ил тод байдлыг бэхжүүлэхийг дэмжих төсөл”-ийн хүрээнд Авлигатай тэмцэх газартай хамтран төрийн албанд анх орох иргэний болон удирдах ажилтны сонгон шалгаруулалтын шалгалтыг цахим хэлбэрээр авах системийг улсын хэмжээнд

¹ Засгийн газрын 2008 оны 65, 2012 оны 14, 2014 оны 327, 2014 оны 382, 2016 оны 03 дугаар тогтоолоор яамдын бүтцийг, Засгийн газрын 2012 оны 43, 2014 оны 387, 2016 оны 04 дүгээр тогтоолоор Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тоог тус тус өөрчилсөн.

нэвтрүүлсэн, шалгалтын үйл явцыг камераар баримтжуулж, шалгуулагч иргэд болон сонирхсон этгээдэд шалгалтын үйл явцыг шалгалтын танхимын гаднах дэлгэцээр ажиглан харах боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр шалгалтын үнэлгээтэй холбоотой гомдол маргаан гарахгүй болсон.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журмын дагуу өнөөдрийн байдлаар яамны удирдах албан тушаалд 42, агентлагын удирдах албан тушаалд 89 хүн түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа бөгөөд 2 жил түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа хүн ч байна. Иймээс түр орлон гүйцэтгэгчээр ажиллах хугацаа болон эрхийн хязгаарлалтыг 2017 онд баталсан Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д тусган хуульчлав.

Тэрчлэн төрийн албаны шударга ёсны зарчмын хүрээнд хуурамч диплом ашигласан, хууль бус томилгоо, удирдах ажилтны ажлын байрны хуульд нийцээгүй шаардлага, хуульд заасан хугацаанд томилгоо хийгээгүй, төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн шийдвэрээр яамны нэгжийн удирдах албан тушаалтныг томилсон, чөлөөлсөн, халсан, түүнчлэн төрийн жинхэнэ албан хаагчдын дунд улс төрийн аль нэг намын Бага хурлын гишүүн, Үндэсний зөвлөлдөх хорооны гишүүн, иргэдийн Хурлын төлөөлөгч нар ажилласан, ажилд эгүүлэн тогтоосон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй зэрэг зөрчлийг арилгуулах, хариуцлага тооцуулах санал, үүрэг даалгавар, зөвлөмж, мэдэгдлийг төрийн холбогдох албан тушаалтан, Төрийн албаны салбар зөвлөлүүдэд хүргүүлж, тодорхой арга хэмжээ авсан.

/Дэлгэрэнгүй мэдээллийг 2 болон 3 дугаар хавсралтаас үзнэ үү/

Төрийн албаны шударга ёсны зарчмын нэг илрэл нь төрийн албан тушаалтан төрийн өмнө үүрэг биелүүлж, хариуцлага хүлээх байдал, ялангуяа гэм буруугийн төлөө хариуцлага заавал хүлээх зарчмын хэрэгжилт билээ. Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2-т зааснаар *албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг* Төрийн албаны зөвлөл өөрөө эсхүл ТАЗ-ийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасны дагуу Салбар зөвлөлд эрх шилжүүлэх хэлбэрээр хэрэгжүүлж байна. Хуульд заасны дагуу төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаас нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг Төрийн албаны зөвлөл Нийслэлд 2 удаа нэхэмжлэл гаргасан боловч шүүх нэхэмжлэлийн хүлээн авахаас татгалзсан.

Иймд Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Аудитын тухай хуулийн уялдаа холбоог хангаж, Төрийн албаны зөвлөл төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах үндэслэлийг тодорхой болгох, мөн дотоод аудитын үйл ажиллагааг журмаар биш, хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзэж байна.

Гурав.Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн хэрэгжилтийн талаар:

Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлд төрийн албан хаагч, иргэнээс мэргэшлийн шалгалт авах, төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, түүнийг томилох, чөлөөлөх, албан тушаалд дэвшүүлэх, албан тушаалаас бууруулах зэрэг асуудлаар хууль тогтоомж,

стандартыг зөрчих, түүнчлэн дээрх үйл ажиллагаатай холбогдсон шударга бус тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа гаргахыг хориглосон билээ.

1/Бүх шатны төрийн захиргааны байгууллагын удирдах, гүйцэтгэх ажилтны сул орон тооны захиалга хүлээн авах, нийтэд зарлах, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, дүгнэлт гаргах нэр дэвшүүлэх, томилгоонд нь хяналт тавьдаг хэдий ч томилох эрх бүхий албан тушаалтнууд сул орон тооны захиалгаа ирүүлдэггүй, түр орлон гүйцэтгэгч томилох, сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг гэрээт ажилтан нэрээр авч ажиллуулах, ажлын байрны шаардлагыг тодорхой хүнд тохируулах, эсвэл тавигдах болзол, шаардлагын шалгуурыг бууруулах, Төрийн албаны зөвлөл, түүний салбар зөвлөлөөс сонгон шалгаруулж, дүгнэлт гаргаж санал болгосон иргэнийг томилохгүй байх, сонгон шалгаруулалтад тэнцээгүй, эсвэл тэнцсэн ч Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтгүй иргэнийг томилох зэрэг зөрчлүүд тасрахгүй гарсаар байна.

Дээрх зөрчлийг гаргасан эрх бүхий албан тушаалтныг төрийн албанд 3 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр төрийн албанаас халах зохицуулалтыг 2019 оны 01 дүгээр сараас мөрдөгдөх Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/-д шинээр тусгасан нь дэвшилттэй зүйл болсон юм. Түүнчлэн хяналт шалгалтын байгууллага /Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран хамтарсан ажлын хэсгийн хүрээнд төрийн албаны томилгоонд хяналт хийж Улсын Их Хуралд танилцуулан зохих арга хэмжээг авах боломж байгаа.

2/ Төрийн албаны зөвлөлөөс төв, орон нутгийн төрийн захиргааны төрийн 93028 албан хаагчдын албан хаагчдын үр дүнгийн гэрээний сүүлийн 3 жилийн үнэлгээнд судалгаа хийхэд 43.2 хувь нь "Маш сайн", 46.46 хувь нь "Сайн", 9.51 хувь нь "Хангалттай", ердөө 0,82 хувь нь дутагдалтай буюу огт хангалтгүй гэсэн үнэлгээ өгчөө. "А" ба "В" үнэлгээний эзлэх жин 89.66% байгаа нь бодит байдалд хэр нийцэж байгаа эсэх нь эргэлзээтэй.

Төрийн албаны тухай хуулийн 35.1.5-д заасны дагуу Төрийн албаны зөвлөл төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлж, холбогдох журмыг² хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлж, хэрэгжилтэд нь дүн шинжилгээ хийж, цаашид боловсронгуй болгох талаар тодорхой санал, санаачлагыг гарган ажиллаж ирлээ. Тухайлбал Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны даргын 2014 оны 11 дүгээр тушаалаар "Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ шинэчлэн боловсруулах" ажлын хэсэг байгуулж, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн уялдаа холбоог хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх, гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг энгийн, хялбар, ойлгомжтой болгох, үнэлгээний бүтцийг сайжруулах, үнэлгээг үндэслэн албан тушаал дэвшүүлэх, үнэлгээний шатлал тогтоох, гүйцэтгэлийг цалин хөлс, урамшуулалтай холбох, хөдөлмөрийн сахилгыг хэрхэн сахиж байгааг үнэлэх, хамт

² 1995-2003 онд "Төрийн захиргааны албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам", 2003-2007 онд "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин, төрийн үйлчилгээний албан хаагчийн үр дүнгийн гэрээг үнэлж, дүгнэх журам", 2007-2012 онд "Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин ЛУДГ-ний биелэлт/-г үнэлэх журам", 2012 онд "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам

олны үнэлгээг авах, өгсөн үүрэг даалгавар, санаачлага, идэвхи зүтгэлийг үнэлэх, ажлын ачааллыг харгалздаг болох зэрэг асуудлуудыг тусган “Үр дүнгийн гэрээ”-г боловсронгуй болгох чиглэлээр ажилласан билээ.

Ажлын хэсэг гадаад орнуудын гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо, Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо, төрийн болон орон нутгийн байгууллагуудад төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг хэрхэн үнэлж байгаа, өмнөх онуудын үр дүнгийн гэрээг дүгнэсэн байдал зэргийг судлан үзэж журмын төслийг боловсруулж байна.

3/ Төрийн албаны зөвлөл Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, төрийн албаны стандартын удирдлагыг хэрэгжүүлэх, ёс зүйн болон бусад зөрчлийг илрүүлж, зөрчил үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах зөвлөмж, шаардлага өгөх, зарим шийдвэрийг хүчингүй болгох, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлэх зэргээр хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд ажилласаар байна.

Төрийн албаны стандартыг хэрэгжүүлэхийн тулд ийнхүү өнөөгийн эрх зүйн орчны хүрээнд Төрийн албаны зөвлөл ажиллаж байгаа хэдий ч улс төрийн сонгууль, Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн, яам, агентлаг, болон аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж, төрийн албан хаагчид шилжилт хөдөлгөөнд орж, тогтвор, суурьшилтэй ажиллах нөхцөл алдагдаж байгаагаас гадна “бүтцийн өөрчлөлт” гэсэн нэрийн дор төрийн албан хаагчдыг ажлаас чөлөөлөх, халах асуудал үргэлжилсээр байгааг дээр дурдсан.

Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн Үндэсний аудитын газрын тайланд *“Яам, агентлагийн төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтныг томилоход Төрийн албаны тухай хууль болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоол, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлөөс баталсан журмыг зөрчих тохиолдол нийтлэг гарсан, Төрийн албаны зөвлөлийн санал дүгнэлт гаргахгүйгээр албан үүргийг түр орлон гүйцэтгэгч томилсон, төрийн албанд жинхлээгүй иргэнийг албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон зөрчил байна. Эдгээр зөрчил, дутагдалтай холбогдуулан төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт, томилгоотой холбоотой асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэх саналыг Төрийн албаны зөвлөлөөс Засгийн газарт удаа дараа тавьсан бөгөөд зөрчил, дутагдлыг арилгах, хууль журмыг дагаж мөрдөх ажил удаашралтай, хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна”* гэж дүгнэсэн байна.

Өнөөгийн байдлаар төрийн албан хаагчийн томилгоо маш олон субъектэд хуваагдаж хуульчлагдсан байгаа төдийгүй улс төрийн албан хаагчид төрийн жинхэнэ албаны томилгоог хийж байгаа нь төрийн алба улс төрөөс ангид байх, ил тод, адил тэгш байх тухай хуулийн зарчмууд зөрчигдөхөд хүргэж байна. Тухайлбал, одоогийн байдлаар 20 шахам хууль, эрх зүйн актаар 110 гаруй ажлын байрны 350 шахам албан хаагчийг томилох, чөлөөлөх эрхийг Засгийн газрын гишүүдэд олгосон байгаа. Энэ нь төрийн албанд улс төрийн нөлөөлөл тусах, томилгоо төрийн албаны хуулийн зарчмаас гажиж байна.

Дөрөв.Төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг бодитойгоор тодорхойлж төрийн байгууллага, албан тушаалтнуудад үзүүлж байгаа мэргэжил арга зүйн дэмжлэгийн талаар:

Төрийн албаны хуулиар төрийн байгууллагын өөрчлөлт, хөгжлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийн төлөвлөлтийн арга зүйн удирдлагаар хангах, төрийн жинхэнэ албаны боловсон хүчний хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах чиг үүрэгт мэргэшил арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангаж ажиллах нь манай Зөвлөлийн нэг чиг үүрэг юм.

Төрийн албаны зөвлөлийн цахим хаягт төрийн байгууллагад гарсан сул орон тоо болон сонгон шалгаруулалтын тухай мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй хүргэж байгаа боловч аймаг, орон нутгийн ажлын байрны сул орон тоо бүрэн нөхөн хангагдахгүй байдал байсаар байна. Тухайлбал, аймгуудын Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, сумдын Мал эмнэлэг, үржлийн тасаг, аймаг, сумдын байгаль хамгаалагчийн ажлын байранд хүн бүртгүүлэхгүй байдал давтагдсаар байна. Дээр дурдсан сул орон тоо бүхий ажлын байранд иргэд бүртгүүлэхгүй байгаагийн шалтгаан нь нэгд, тухайн ажлын байранд тавигдсан шаардлагад нийцэх боловсрол, мэргэжилтэй хүн орон нутагт хүрэлцэхгүй, хоёрт, цалин хөлс бага, гуравт, хөдөө орон нутаг, алслагдсан сумдад ажиллах хүсэл сонирхолтой иргэн цөөн байгаатай холбоотой. Ихэнх ажлын байрыг 2-3 удаа зарлаад нөхөгдөхгүй, зарим ажлын байр 6-8 удаа зарлагддаг. Мэргэжлийн чиглэлээр нь авч үзвэл, анагаах /хүний эмч, хүүхдийн эмч, эм зүйч, эрүүл ахуйч, халдвар судлаач г.м/, хөдөө аж ахуйн /малын эмч, мал зүйч, агрономич, хөдөө аж ахуйн инженер г.м/, инженер /барилга, авто зам, цахилгаан/, мэргэжилтэй хүмүүсийн захиалга орон нутагт хэрэгцээтэй байна.

Ажлын байрны нөхөн хангалтын байдал болон ялангуяа орон нутгийн сул орон тоо нөхөгдөхгүй байгаа асуудлыг Төрийн албаны зөвлөл хуралдаанаараа хэлэлцээд, энэ судалгааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, иргэд бүртгүүлэхгүй байгаа ажлын байрны талаар холбогдох арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд нийгмийн баталгааг нь хэрхэн хангах, боловсон хүчин бэлтгэх, зарим албан тушаалуудыг төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд шилжүүлж болох эсэх талаар тодорхой санал боловсруулах хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллах талаар санал тавьсан боловч тодорхой хариу ирүүлээгүй.

Нийт зохион байгуулагдсан мэргэшлийн шалгалтын товч мэдээ:

№	Он	Зарласан ажлын байрны тоо	Шалгалт өгсөн иргэний тоо	Шалгалтад тэнцсэн иргэн	
				тоо	хувь
1	2010	907	4573	3104	48.1%
2	2011	1009	5300	3705	69,91
3	2012	1065	6280	3647	58,07
4	2013	1489	9732	1999	20.5%
5	2014	1997	13618	3475	26%
6	2015	1091	10209	2790	27.30%
7	2016	544	5236	1828	34.91%
8	2017	744	8455	2846	33.66%

Мэргэшлийн шалгалтын бүтэц, агуулгыг шинэчлэх, сонгон шалгаруулах журам, заавар, аргачлалыг боловсронгуй болгох чиглэлээр ажлын хэсгийг байгуулж аймаг, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүд, төрийн байгууллагууд, судлаачдаас ирүүлсэн санал, хүсэлт болон өмнөх практикийг эргэн харж судалсны үндсэн дээр Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 86 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”, “Төрийн жинхэнэ албанд анх ороход авах мэргэшлийн шалгалтын үнэлгээ дүн, гаргах заавар” гэсэн баримт бичгүүдийг шинэчлэн баталж мөрдүүлж байна.

Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт, сонгон шалгаруулалтад оролцох иргэдэд зориулж хэвлэсэн гарын авлагыг Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хүний эрхийн Үндэсний комисс, Авлигатай тэмцэх газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Жендерийн үндэсний хороо, Тагнуулын ерөнхий газар, Удирдлагын академи, Хуульчдын холбоо, Хэлний бодлогын үндэсний зөвлөл, хуульч, эрдэмтэн судлаачдын оролцоо дэмжлэгтэйгээр шинэчилж, албан хэрэгцээний болон нийтийн хэрэгцээнд гаргасан болно. Энэхүү гарын авлагад Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хүний эрхтэй холбоотой хууль тогтоомж, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөрөөс боловсруулсан сорилыг нэмж оруулав.

Тав.Ажлаас хуулийн үндэслэлгүйгээр халагдсан албан хаагчдыг албан тушаалд нь эгүүлэн томилсон шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар:

Төрийн албаны тухай хууль зөрчин ажлаас үндэслэлгүй халсан, чөлөөлсөн, зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн гэх зэрэг үндэслэлээр албан тушаалтнуудын гаргасан шийдвэрийг үндэслэлгүй болохыг шүүхээс тогтоосон байдлыг оноор нь авч үзвэл:

Он	Ажилд нь эгүүлэн тогтоосон албан хаагч	Шүүхийн шийдвэр биелэсэн	Шүүхийн шийдвэр биелээгүй	Ажилгүй байсан хугацааны цалин /мян.төг/	Цалинг гаргуулсан / мян.төг/	Цалингийн үлдэгдэл / мян.төг/
2013 он	90	57	33	207976.8	152069.1	55907.7
2014 он	143	102	41	479556.8	391989.5	87567.3
2015 он	253	174	79	852218.9	509759.8	342459.1
2016 он	329	218	111	1451912.4	850900.34	601012.1
2017 он	319	213	105	1217267.7	936127.7	281140
2018 оны эхний хагас жил	264	117	146	1222174.0	524722.043	697451.967

Өмнөх онд шийдвэрлэгдээгүй үлдсэн шүүхийн шийдвэрийг дараа оны шийдвэр дээр нэмж шийдвэрийн гүйцэтгэлийг хангуулах ажиллагаа явагддаг бөгөөд 2013 оноос 2018 оны эхний хагас жил хүртэл 1127 төрийн албан хаагчийг эрхэлж байсан албан тушаалд нь эгүүлэн томилох шүүхийн шийдвэр гарсан ба 2018 оны эхний хагас жилийн байдлаар 146 шийдвэр биелээгүй байна.



Шүүхийн шийдвэрээр ажилд нь томилохоор тогтоосон боловч 2018 оны эхний хагас жилийн байдлаар ажилд нь томилоогүй байгаа 146 албан хаагчийг байгууллагаар авч үзвэл: Яам 16, яамны харьяа байгууллага 11, агентлаг 11, нийслэл-13, аймаг 80, төрийн өмчит байгууллага 7, төрийн бусад байгууллага 8, албан тушаалын хувьд авч үзвэл: удирдах албан тушаалтан 77, гүйцэтгэх албан хаагч 70/ 697,451,967 төгрөгийн нөхөн олговор олгогдоогүй байна.

Шүүхийн шийдвэрээр албан тушаалд нь эгүүлэн томилсон боловч өнөөдрийг хүртэл ажилд томилогдоогүй албан хаагчдын тоо

/2010-2018 оны эхний хагас жил/

№	Ангилал	Тоо	Удирдах	Гүйцэтгэх
1.	Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл	1	1	
2.	Монгол Улсын Засгийн газраас томилох	3	3	
3.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	1		1
4.	Үндэсний аудитын газар	1		1
5.	Монгол банк	2	2	
6.	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	2		2
7.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	4	4	
8.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	2	2	
9.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	3	1	2
10.	Эрүүл мэндийн яам	4	3	1
11.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	1	1	

12.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	1	1	
13.	Оюуны өмч улсын бүртгэлийн ерөнхий газар	3		3
14.	Цагдаагийн ерөнхий газар	2	2	
15.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл	1		1
16.	Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газар	1	1	
17.	Стандартчилал хэмжилзүй газар	1		1
18.	Төрийн өмчий бодлого зохицуулалтын газар	1	1	
19.	Гаалийн ерөнхий газар	1		1
20.	Хууль зүйн үндэсний хүрээлэн	1		1
21.	Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэн	1	1	
22.	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори	1	1	
23.	Сэргээн засах сургалт үйлдвэрлэлийн төв	1		1
24.	Үйлдвэр урлагийн политехникийн коллеж	1		1
25.	Үлэг гүрвэлийн музей	1		1
26.	Хүнс хөдөө аж ахуйн бирж	1		1
27.	Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс	4		4
28.	Нийслэл	13	10	3
29.	Баян-Өлгий	20	5	15
30.	Баянхонгор	3	3	
31.	Говь-Алтай	13	4	9
32.	Говьсүмбэр	4	3	1
33.	Дархан-Уул	3	2	1
34.	Дорноговь	2	2	
35.	Дорнод	2	2	
36.	Дундговь	6	2	4
37.	Завхан	1		1
38.	Орхон	4	3	1
39.	Сүхбаатар	8	7	1
40.	Төв	1	1	
41.	Увс	10	4	6
42.	Ховд	3	1	2
43.	Төрийн өмчит байгууллагууд	7	3	4
Нийт		146	77	69

Төрийн байгууллагуудын бүтцийн өөрчлөлтийг богино хугацаанд олон удаа хийсний улмаас төрийн албан хаагчдын хөдөлгөөн ихсэж, төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг алдагдуулахад хүргэж байна. Энэ нь төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хуулийн дагуу бүрэн хангагдахгүй байгааг харуулж байгаагаас гадна төрийн албан хаагчийг өмнө

эрхэлж байсан ажил, албан тушаалд эгүүлэн тогтоох, ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх, дэвтэрт нөхөн бичилт хийх ажиллагаа хангалтгүй, төрийн албаны үйл ажиллагаа тасралтгүй, тогтвортой байх баталгаа бүрэн хангагдахгүй байна.

Шүүхийн шийдвэрээр албан тушаалд нь эгүүлэн тогтоосон боловч 2018 оны эхний хагас жил хүртэл ажилд нь эгүүлэн томилоогүй албан хаагчийн тоог дараахь хүснэгтээс харж болно.

№	Шийдвэр гаргасан он	Тоо
1	2010 он	2
2	2013 он	1
3	2014 он	2
4	2015 он	8
5	2016 он	22
6	2017 он	100
7	2018 оны эхний хагас	11
Нийт		146

2017 онд УИХ-аас баталсан Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 50 дугаар зүйлд "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ." гэж заасан.

Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс мөрдөж эхэлснээр төрийн алба улс төрийн сонгуулийн мөчлөг дагаж өөрчлөгддөг, улс төрөөс хараат байдлаар томилгоо хийх явдал эцэс болно.

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасан төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг Төрийн албаны зөвлөл, түүний салбар зөвлөл Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу хянан шийдвэрлэдэг.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс гаргаж судалгаанаас үзэхэд 2013-2017 онд Захиргааны хэргийн Анхан шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн хэрэг маргааны 27,5%, Давж заалдах шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн нийт хэрэг маргааны 16,3%, Хяналтын шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн нийт хэрэг маргааны 20,4% нь төрийн албан хаагчийг албан тушаалаас чөлөөлөх, халах болон төрийн албаны хүний нөөцтэй холбоотой хэрэг, маргаан байх бөгөөд давхардсан тоогоор нийт

13885 хэрэг маргаан хянан шийдвэрлэснээс 3124 буюу 22,4 хувь төрийн албан хаагчтай холбоотой хэрэг, маргаан эзэлж байна.


/дэлгэрэнгүйг 4 дугаар хавсралтаас үзнэ үү/

Зургаа. Гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон төрийн албан хаагчдын төрд учруулсан хохирлын талаар:

Төрийн албан хаагчдаас 2013-2018 оны эхний хагас жилийн байдлаар 1235 төрийн албан хаагч гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь шүүхээр тогтоогдож, 47,6 хувь хорих, 15,4 хувь нь тодорхой хугацаагаар албан тушаал эрхлэх эрхийг хасах, 12,5 хувь нь торгох ялаар шийтгүүлжээ. Ял шийтгүүлсэн албан хаагчийн албан тушаалын ангилал, ялын төрлийг дараахь хүснэгтээс харж болно.

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл

№	Он	Гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон төрийн албан хаагчдын тоо	Төрийн албан тушаалын ангилал,				Оногдуулсан ял					
			Улс төрийн албан тушаалтан	Төрийн захиргааны албан хаагч	Төрийн тусгай албан хаагч	Төрийн үйлчилгээний албан хаагч	Торгох ял /төг/	Албадан ажил хийлтэх ял	Баривчлах ял	Хорих ял	Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа эрхлэх эрх хасах	Эд хөрөнгө хураах /төг/
1	2013	218	8	46	51	113						
2	2014	228	16	56	82	110	20	4	16	181	81	19
3	2015	203	21	43	61	131	28	21	15	138	45	11
4	2016	204	13	32	75	130	15	11	4	174	37	10
5	2017	214	20	31	62	101	92	10	3	94	28	7
6	2018 /эхний хагас жил/	168	12	26	54	76						
Нийт		1235	90	234	385	661	155	46	38	587	191	47



Гэмт хэрэг үйлдсэн нийт төрийн албан хаагчдыг ангиллаар нь авч үзвэл улс төрийн албан хаагч 7,2 хувь, төрийн захиргааны албан хаагч 18,9 хувь, төрийн тусгай албан хаагч 31,1 хувь, төрийн үйлчилгээний албан хаагч 53,5 хувийг тус тус эзэлж байна.

Гэмт хэрэг үйлдсэн төрийн албан хаагчдын 5 жилийн дунджийг нийт төрийн албан хаагчдын сүүлийн 5 жилийн дундаж тоотой харьцуулан үзэхэд жилд дунджаар 213 буюу 0,1 хувь нь гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлжээ.

Дээрх судалгаанаас үзэхэд гэмт хэрэг үйлдсэн төрийн албан хаагчдын тоо буурахгүй, бага зэрэг өсөх хандлагатай байгаа тул төрийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх талаар төрийн байгууллага бүр анхаарч ажлын хариуцлага, сахилга дэг журам, ёс зүйг сайжруулах талаар бодит ажил хийх шаардлагатайг харуулж байна.

2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөх Төрийн албаны тухай хуулиар авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон төрийн албан хаагчийг төрийн албанд эргэж орж ажиллахыг хориглосон.

Долоо.Албан тушаалтны хууль бус шийдвэрийн улмаас төрд учруулсан хохирлын талаар:


Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 2-д “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж заасан.

Нийтийн өмчийг удирдах, хянах, хадгалж хамгаалах үүрэг бүхий төрийн албан тушаалтны хууль бус шийдвэрийн улмаас төрд учруулсан хохирлын хэмжээ жил бүр өсөх хандлагатай байгааг дараахь хүснэгтээс харж болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхийгазраас ирүүлсэн судалгаанд үндэслэв./

№	Он	Төрд хохирол учруулсан албан тушаалтны тоо	Төрд учруулсан хохирлын хэмжээ
1	2013	31	369.718,6
2	2014	29	474.035,7
3	2015	70	2.116.047,2
4	2016	29	1.353.178,3
5	2017	53	4.224.380,4
6	2018 оны эхний хагас жил	115	5.888.950,7
Нийт		327	14.426.311,0

Шүүхээс 2013-2018 оны эхний хагас жилийн хооронд төрийн албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас төрд учруулсан мөнгөн хохирол 14.426.311 сая төгрөгт хүрсэн байна.



Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д Албан тушаалтны хууль бус үйлдлийн улмаас учруулсан хохирлыг төр хариуцаж, харин төр өөрт учирсан хохирлоо буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд төрд учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж, уг нэгж байхгүй бол төрийн аудитын байгууллага хүлээсэн боловч хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа хийгдэхгүй байна.

/Дэлгэрэнгүйг 4 дүгээр хавсралтаас үзэх/

—oOo—

Төрийн албаны эвлэлийн 2018 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 26 тооллын дугаар хавсралт

Төрийн албаны зөвлөлөөс хууль дээдлэх, шударга ёсыг хэрэгжүүлэх чиглэлээр гаргасан он оны тогтоолуудаас хураангуйлсан жагсаалт

№	ТАЗ-ийн тогтоолын огноо, дугаар	Ямар байгууллагад явуулсан	Тогтоолын агуулга		Зөвлөмж болгосон	Тогтоол, албан ёсийн агуулга	Бүтээсэн
			Хил хамгаалах ерөнхий газрын дэргэдэх СЗ	Хил хамгаалах байгууллагад орох мэргэшлийн шалгалт авах журам			
1	2014.01.24 № 08	Хил хамгаалах ерөнхий газрын дэргэдэх СЗ	Хил хамгаалах байгууллагад орох мэргэшлийн шалгалт авах журам	Хил хамгаалах байгууллагад орох мэргэшлийн шалгалт авах журам	1	УЛАОТТБ	Бүтээсэн
2	2014.01.30 № 12	Гадвад харилцааны яамны дэргэдэх СЗ	Гадвад харилцааны яамны дэргэдэх СЗ	Дипломат албанд орох мэргэшлийн шалгалт авах журам	1		
3	2014.01.30 № 13	Төв аймаг дахь СЗ	Төв аймаг дахь СЗ	Төв аймаг дахь СЗ-ийн 2013 оны 39 дугаар тогтоолыг хүчингүй болгох			Төв аймгийн Сэргэлэн сумын ЗДТ-ын дарга С.Ганчимэгээс
4	2014.02.24 № 20	Салбар зөвлөлүүдэд	Салбар зөвлөлүүдэд	Төв, Хэнтий, Дархан уул аймг, Гадвад харилцааны яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Эдийн засгийн хөгжлийн хороо Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх СЗ-үүд үйл ажиллагаагаа эрчимжүүлэх	1		
5	2014.03.07 № 33	Төхөрийн ерөнхий газрын дэргэдэх СЗ	Төхөрийн ерөнхий газрын дэргэдэх СЗ	Төхөрийн албанд орох мэргэшлийн шалгалт авах журам	1		
6	2014.04.04 № 43	Гавлийн ерөнхий газрын дэргэдэх СЗ	Гавлийн ерөнхий газрын дэргэдэх СЗ	Гавлийн байгууллагад орох мэргэшлийн шалгалт авах журам	1		
7	2014.04.07 № 44	ЧД-ийн Хөдөлмөрийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид	ЧД-ийн Хөдөлмөрийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн "Ажлаас чөлөөлөх" 2014.01.20-ны өдрийн БЮ4 дүгээр тушаалыг хүчингүйд тооцох	ЧД-ийн Хөдөлмөрийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн "Ажлаас чөлөөлөх" 2014.01.20-ны өдрийн БЮ4 дүгээр тушаалыг хүчингүйд тооцох			ЧД-ийн Хөдөлмөрийн хэлтэст мэргэжилтнээр ажиллаж байсан Д.Удавас
8	2014.05.02 № 51	Баянхонгор аймаг дахь СЗ	Баянхонгор аймаг дахь СЗ	Баянхонгор аймаг дахь СЗ-ийн 2014.01.29-ний 03 дугаар тогтоолын холбогдох заалтыг хүчингүй болгох			Баянхонгор аймгийн ЗДТ-ын Хүүсэд, гэр бүл хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Д.Оюунсурагнаас
9	2014.06.16 № 72	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх СЗ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх СЗ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад орох мэргэшлийн шалгалт авах журам	1		
10	2014.06.16 № 73	Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх СЗ	Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад орох мэргэшлийн шалгалт авах журам	Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад орох мэргэшлийн шалгалт авах журам	1		
11	2014.07.10 № 91	Сангийн яам	Сангийн яам	Ч.Жигжидийг чөлөөлөх Сангийн сайдын "Ажлаас чөлөөлөх" 2014.04.16-ны 86 дугаар тушаалыг хүчингүй болгох			Татаарын ерөнхий газрын дэд дарга асан Ч.Жигжидээс
12	2014.07.10 № 92	Зам тээврийн яам	Зам тээврийн яам	ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын "Ажлаас чөлөөлөх" 2014 оны 205 дугаар тушаалыг хүчингүй болгох тухай			ЗТЯ-ны Авто тээврийн бодлогын хэрэгжлтийг зохицуулах газрын даргаар ажиллаж байсан Д.Балбаатарас
13	2014.08.29 № 97	Хөвсгөл аймаг дахь СЗ	Хөвсгөл аймаг дахь СЗ	Хөвсгөл аймаг дахь СЗ-өөс 2014.07.19-нд зохион байгуулсан сонгон шалгуулалтыг хүчингүй болгох			Иргэн Б.Баянмөнх, О.Өлзийтөгтох нарын 6 иргэнээс
14	2014.09.19 № 103	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014.08.08-ны Б/92 дугаар тушаалыг хүчингүйд тооцох			Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжлтийг зохицуулах газрын даргаар ажиллаж байсан Ц.Рэнчинсэлэнгээс
15	2014.09.29 № 109	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2014.07.14-ний "Ажлаас чөлөөлөх" 285 дугаар тушаалын холбогдох хэсгийг хүчингүй болгох			Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хяналт, ширхэгтээ, үндэсний хэлтсийн ахлагч байцаагч Л.Оюунболгалээс
16	2014.09.29 № 110	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2014.07.16-ны "Орон тоо батлах тухай" 284 дүгээр тушаалын холбогдох хэсгийг хүчингүй болгох	1		
17	2014.10.09 № 113	Дорнод аймгийн Засаг дарга	Дорнод аймгийн Засаг дарга	Дорнод аймгийн Засаг даргын 2013.08.13-ны Б/40 дүгээр зөвлөмжийг хүчингүй болгох			Дорнод аймгийн Засаг даргын орлогч М.Бадамсүрэнгээс

18	2014.10.17 № 119	Архивын ерөнхий газар	Архивын ерөнхий газрын даргын 2014.05.14-ний "Ахлаас халах" тухай Б/14 дүгээр тушаалыг хүчингүйд тооцох				Архивын ерөнхий газрын Сургалт судалгааны газрын даргаар ажиллаж байсан Д.Батсух
19	2014.10.24 № 125	Дорнод аймаг дахь Салбар зөвлөл	Дорнод аймаг дахь СЗ-ийн 2014.05.16-ны 22 дугаар тогтоолыг хүчингүйд болгох	1			Хан-уул дүүрэг дэх Цэгдэвгийн 2 дугаар хосгийн өмчлөх байцаагч А.Батсух
20	2014.12.19 № 163	Цэгдэвгийн ерөнхий газрын дэргэх СЗ	Цэгдэвгийн ерөнхий газрын даргын 2014.07.04-ний 459 дүгээр тушаалын А.Батсухад холбогдох хэсгийг хүчингүйд тооцох				Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжлтийг зохицуулах газрын даргаар ажиллаж байсан Д.Тунгалгавас
21	2015.01.16 № 06	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нэрийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ганцбалын "Албан тушаалд томилгох" 2014.12.19-ний Б/02 дугаар тушаалыг хүчингүйд болгох				Булган аймгийн Дашинчигэн сумын Нийгмийн даатгалын байцаагчаар ажиллаж байсан Ж.Батсурунас
22	2015.01.16 № 07	Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яамны дэргэдэх СЗ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх СЗ-ийн 2014.12.11-ний 30 дугаар тогтоол, Булган аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын "Ахлаас халах тухай" 2014.10.28-ны Б/34 дүгээр тушаалыг устусуу хүчингүйд тооцох				
23	2015.01.19 № 08	Хөвсгөл аймаг дахь СЗ	1.Зөвлөхийн дагуу төлөвлөгөө гарган, 2015.06.15-ны дотор тайлагнах 2.СЗ-ийн н-б/д Д.Байбасураг чөлөөлөх 3..СЗ-ийн дарга Г.Төмөрбаатарт арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга А.Эрдэнэбаатарг мэдэгдэх	1			
24	2015.01.26 № 14	Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх СЗ	Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх СЗ-ийн 2014.11.25-ны 64 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцох				Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга Х.Баярхуягаавас
25	2015.02.06 № 24	Барилга хот байгуулалтын яамны дэргэдэх СЗ	1.Газрын харилцаа төсвөн зураг зүйн газрын дарга А.Хүрэлшатайд харууллага тооцохыг Засгийн газарт санал болгох 2.Зөрчил арилгуулах төлөвлөгөө гаргуулан, биелэлтийн тайлан 2015.03.30-ны дотор нэрүүлэхийг СЗ-д уурсаг болгох	1			
26	2015.02.13 № 30	Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх СЗ	Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх СЗ-ийн 2015.01.05-ны 01 дүгээр тогтоолын холбогдох хэсгийг хүчингүйд тооцох				Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын улсын бүртгэгчээр ажиллаж байсан Э.Мөнхзаяагаас
27	2015.02.13 № 31	Дундговь аймгийн Гуравансайхан сумын Засаг даргад	Дундговь аймгийн Гуравансайхан сумын Засаг даргын "ажлаас халах тухай" 2015.01.05-ны Б/01 дүгээр захирамжийг хүчингүйд тооцох				Дундговь аймгийн Гуравансайхан сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ажиллаж байсан Б.Энхтүгялаас
28	2015.02.16 № 32	Салбар зөвлөлүүдэд	Сурбаатар, Архангай, Говь-Алтай, Баянхонгор, Эрүүл мэндийн яам, Гадвад харилцааны яам, Төрийн өмчийн хэргийн хорооны дэргэдэх СЗ-үүд үйл ажиллагаагаа эрчимжүүлэх ажил зохион байгуулах дүнг 2015.06.30-ны дотор ирүүлэх	1			
29	2015.03.06 № 40	Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын яамны дэргэдэх СЗ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх СЗ-ийн 2015.02.13-ний 05 дугаар тогтоол, Сурбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын "Сахилгын шийтгэл ногдуулах тухай" 2014.11.21-ний Б/60 дугаар тушаалыг устусуу хүчингүйд тооцох				Сурбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн орлого шийтгэлийн байцаагч айсан Д.Энхтөгсөөс
30	2015.03.12 № 48	Сурбаатар аймаг дахь СЗ	Зөвлөхийн дагуу төлөвлөгөө гарган, 2015.06.30-ны дотор тайлагнахыг СЗ-ийн дэргэд даатгах 1. Говьсүмбэр аймгийн Боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Ганбаарын "Сахилгын шийтгэл ногдуулах тухай" 2015.01.20-ны А/012 дүгээр тушаалыг хүчингүйд тооцох 2.ТАЗ-ийн тогтоолын биелэлтийг хангах ажиллахыг СЗ-д уурсаг болгох	1			
31	2015.03.27 № 70	Говьсүмбэр аймаг дахь СЗ		1			С.Энх-Амгалангас

32	2015.05.08 № 98	Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх СЗ	1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Ц.Пүрэвдоржид савалтын хариуцлага тооцох саналыг Засгийн газарт хүргүүлэх 2. ТАЗ-ийн шийдвэр зөвлөмжийн дүнг 2015.06.18-ны дотор ирүүлэхийг СЗ-д үүрэг болгох	1	1	
33	2015.05.08 № 100	Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх СЗ	1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын "албан үүргийг түр орон гүйцэтгүүлэх тухай" 2014.06.24-ний 853, 2014.12.24-ний 1765, 2015.03.09-ний 383 дугаар тушаалуудыг хүчингүй болгох 2. ТАЗ-ийн тогтоол 1 дэх хэсэгт байгаа албан тушаалын сонгон шалгаруулалтыг 2015.08.15-ны дотор зохион байгуулахыг СЗ-д үүрэг болгох			
34	2015.06.03 № 115	Гаалийн ерөнхий газрын даргад	Гаалийн ерөнхий газрын даргын 2015.04.10-ны "авчлаас чөлөөлж, томилгох тухай" Б/102 дугаар тушаалаас Ч. Энхзэг чөлөөлсөн хэсгийг хүчингүй болгох		1	Ч.Энхзэгээс
35	2015.06.03 № 116	Гаалийн ерөнхий газарт	1. Гаалийн ерөнхий газрын даргын сонгон шалгаруулалтыг хуульд нийцүүлэхийг Засгийн газарт зөвлөх 2. Зөрчил арилгуулах төлөвлөгөө гаргуулан, биелэлтийн тайлан 2015 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх	1	1	
36	2015.08.12 № 127	Увс аймаг дахь СЗ	1. Зөрчил арилгуулах төлөвлөгөө гаргуулан, биелэлтийн тайлан 2015.12.20-ны дотор ирүүлэх 2. Гаалийн ерөнхий газрын даргын 2015.07.07-ны Б/262 дугаар тушаалын Б.Батсүү, Ө.Баярсайван 3. Цолмон, Ц.Жаргал, Т.Гүндэлэл, Б.Хишигжаргал, Э.Мөнхсүлд, Ж.Алтанбат, Б.Балсалсан, Б.Болор нэрт холбогдох хэсгийг хүчингүй болгох 2. Гаалийн байгууллагад орох мэргэшлийн шалгалтын журмыг мөрдөж ажиллах 3. Нөөцөд бүртгэлтэй иргэдийг гаалийн байцаагчаар томилгодоо чиглүүлэх сургалтын хугацааг мөрдөх 4. Тогтоолын биелэлтийг 2015.09.10-ны дотор ирүүлэх	1	1	
37	2015.08.04 № 158	Гаалийн ерөнхий газарт			1	
38	2015.10.05 № 167	Хөдөлмөрийн яамны дэргэдэх СЗ	1. Хөдөлмөрийн яамны дэргэдэх СЗ-ийн 2015.06.15-ны 13 дугаар тогтоолын хавсралтад зөвсөн Р.Бадансамбуут Завахан аймаг дахь Тосонцригэл сумын МСҮТ-ийн захирлын албан тушаалд нэр дэвшүүлсэн хэсгийг хүчингүйд тооцох 2. Сонгон шалгаруулалтыг дахин явуулахыг даалгах		1	иргэн Д.Очирбатыас
39	2015.11.02 № 192	Батлан хамгаалах яам	1. Батлан хамгаалах яамны Төрийн захиргаа Уандраагийн газрын дарга, Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газрын даргын албан тушаалын сул орон тоонд түр орлон гүйцэтгэгчээр томилсон Төрийн нарийн бичгийн даргын 2015.01.29-ний Б/17, 2015.08.25-ны Б/166 дугаар тушаалыг хүчингүйд тооцох 2. Ч.Сосорбарам, С.Ганбагба, Д.Ганхуяг нарыг Уандраагийн албан тушаалд томилсон шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэх 3. Төрийн захиргааны удирдлагын даргын нээлттэй сонгон шалгаруулалтыг 2015.11.25-ны дотор зохион байгуулах		1	
40	2015.11.02 № 192	Дорнод аймаг дахь СЗ	1. Төрийн албаны зөвлөлийн СЗ-ийн ажиллах журамд зөвсөн чиг үүргийг эрчимжүүлэх 2. Зөвлөлийн шийдвэр, Ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөмжийн дагуу хийсэн ажлын хэрэгжилтийн тайланг 2016.01.15-ны дотор ирүүлэх	1	1	

41	2015.12.31 № 228	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын даргын "Саяхлын шийтгэл нөдүүлэх тухай 2015.10.21-ний Б/166 дугаар тушаалыг хүчингүй болгох	Мэргээн хянан шийдвэрлэх тухай	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын даргын "Саяхлын шийтгэл нөдүүлэх тухай 2015.10.21-ний Б/166 дугаар тушаалыг хүчингүй болгох	1	"Албан тушаалаас халах тухай" ШЕЗ-ийн 2015-09-07 ны 49 тогтоолыг хүчингүй болгосугай	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын Эрх зөвшөөрлийн газрын мэргэжилтэн Ж.Очиртуяагаас
42	2016/02/23/23	Шүүх Ер Зөвлөл	Мэргээн хянан шийдвэрлэх тухай	Мэргээн хянан шийдвэрлэх тухай	Мэргээн хянан шийдвэрлэх тухай			
43	2016/03-28-37	Сангийн яам	Зөвлөмж хэрэгжүүлэн ажиллах, тайлагнах тухай	Зөвлөмж хэрэгжүүлэн ажиллах, тайлагнах тухай	Зөвлөмж хэрэгжүүлэн ажиллах, тайлагнах тухай		Үйл ажиллагааны үнэлгээ сүүлийн 4 жилээр буурсан байгаа тул буурсан үзүүлэлтүүрийг сайжруулах талаар	
44	2016/04/15-44	ХАХНХЯ	Зөвлөмж хэрэгжүүлэн ажиллах, тайлагнах тухай	Зөвлөмж хэрэгжүүлэн ажиллах, тайлагнах тухай	Зөвлөмж хэрэгжүүлэн ажиллах, тайлагнах тухай		TATX-ийн 17.5 заасны дагуу ажлын байрыг нээлтэй мэдээлэх Үүрэгтэй гэх заасны дагуу	
45	2016/05/31/60	Нийс. Хүүх. Зал. Хөгжлийн газар	Мэргээн хянан шийдвэрлэх тухай	Мэргээн хянан шийдвэрлэх тухай	Мэргээн хянан шийдвэрлэх тухай		Дүгнэлт гаргах тухай Нийслэл дэх салбар зөвлөлийн 2016-04-18-08 дугаар тогтоолыг хууль зүйн үндэслэлгүй гэсэн дүгнэлтийг гаргасан	
46	2016/06/10/62	Арвантуй аймаг дахь салбар зөвлөл	Дүгнэлт гаргах, үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай	Дүгнэлт гаргах, үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай	Дүгнэлт гаргах, үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай		ТАЗ-ийн тогтоол, Ажлын хэргийн дүгнэлт болон энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах/ биеэлтийг 2016-09-15-ны дотор ирүүлэх!	
47	2016/06-27/67	Дөрхөн Уул аймаг дахь салбар зөвлөл	Мэргээн хянан шийдвэрлэх тухай	Мэргээн хянан шийдвэрлэх тухай	Мэргээн хянан шийдвэрлэх тухай		Дөрхөн Уул аймгийн Засаг даргын 2016-05-05 Б/40 дүгээр заррамыг Хүчингүйд тусгах	
48	2017/08/12/118	Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл	Мэргээн хянан шийдвэрлэх тухай	Мэргээн хянан шийдвэрлэх тухай	Мэргээн хянан шийдвэрлэх тухай		Нөөцөд бүртгэх нэр дэвшүүлэх тухай ТАЗ-ийн Баянхонгор дахь салбар зөвлөлийн 2017/03/07-08 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай	
49	2017/09/29/148	Өмнөговь аймаг дахь салбар зөвлөл	Мэргээн хянан шийдвэрлэх тухай	Мэргээн хянан шийдвэрлэх тухай	Мэргээн хянан шийдвэрлэх тухай		Өмнөговь аймаг дахь салбар зөвлөлийн 2017/04/04/18 тогтоолын хууль зүйн үндэслэлийг дахин хянан шалгуулахаар Салбар зөвлөлд Хүргүүлэх	
50	2017/09/29/150	БСШУЯам	Мэргээн хянан шийдвэрлэх тухай	Мэргээн хянан шийдвэрлэх тухай	Мэргээн хянан шийдвэрлэх тухай		Ажлаас чөлөөлөх тухай БСШУЯ-ны 2017/08/16-ны өдрийн Б/119 дүгээр тушаалын заалтыг хүчингүй болгох	
51	2017/09/29/149	Увс аймгийн Өмнөговь сумын ИТХ	Мэргээн хянан шийдвэрлэх тухай	Мэргээн хянан шийдвэрлэх тухай	Мэргээн хянан шийдвэрлэх тухай		Сул орон тоог нөхөх нээлттэй сонгон шалгаруулалтыг ТАТХ-ын 17.5-А заасны дагуу нийгэд 2017/10/20-ны дотор зөрлөх	

52	2018.03.20 № 12	Хэнтий аймаг дахь СЗ	<p>1.Хэнтий аймагын ЕБС-ийн 1 захирлын, 3 цэцэрлэгийн эрхлэгчийн сонгон шалгаруулалтыг товлосон хугацаанд хийгээгүй, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга С.Мөнхцэцэгт хариуцлага тооцон 2018.04.02-ны дотор харну мэдэгдэхийг Засаг дарга Н.Ганбаяадад уламжлах</p> <p>2.Төрийн үйлчилгээний албаны Үндирдэх албан тушаалын сонгон шалгаруулалтыг арга зүйн удирдлагаар хангаж, зөвлөж ажиллахыг үүрэг болгох</p>	1	1	
206	2016.09.08 №912	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.БАТЖАРГАЛ	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох ажилтныг Төрийн албаны тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ыг зөрчин томилоо хийснийг Төрийн албаны зөвлөл хүлээн зөвшөөрөх боломжгүй тул таны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулж, Төрийн албаны тухай хуулийн дагуу томилогдох хүртэл хугацаанд бүтцийн нэгжийн дарга болон гүйцэтгэх албан тушаалтанд Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргах боломжгүйг үүгээр мэдэгдье.		1

207	2016.09.09 №925	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ	1-үс агентлагийн 1 өрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн даргын, Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн даргын албан тушаалд томилгоо хийх эрх бүхий албан тушаалтан нь Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 351 дугаар зүйлийн 351.1.6, Засгийн газрын тухай хуулийн 183 дугаар зүйлийн 1832, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2003 оны "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам", уг журмын 9-ийн "а"-д тус тус заасны дагуу төрийн албанд томилогдоогүй байх тул тус агентлагийн даргын сонгон шалгаруулалт, томилгооны дараа зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нарт дүгнэлт гаргах асуудлаа хууль тогтоомжийн дагуу манай Зөвлөлд гаргах нь зүйтэй гэж үзээд танай хүсэлтийг үүгээр буцааж байна			1
208	2016.09.15 №937	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМАНД	Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Үнэнбатын 2016 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн Б/04 дүгээр тушаалын 2-т "Тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан албан хаагчдыг Хууль зүй, дотоод хэргийн яамны албан хаагчдын нөөцөд байгаад тооцож, ажлын байраар хангах арга хэмжээ авахыг Төрийн захиргааны удирдлагын газарт үүрэг болгосугай" гэж заасан байх бөгөөд уг тушаалын гуравдугаар хавсралтад тус яамны ахлах мэргэжилтэн Д.Ундармааг зохих албан тушаалд томилж, төрийн захиргааны албан Иймд ахлах мэргэжилтэн Д.Ундармааг зохих албан тушаалд томилж, төрийн захиргааны албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж ажиллана уу.	1		1
209	2016.09.16 №950 ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧТА НАА	Зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах тухай Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-д заасны дагуу сонгон шалгаруулалтын үр дүнгээр тухайн албан тушаалд албан ёсоор томилогдоогүй, түр орлон гүйцэтгэгчээр ажиллах хугацаандаа төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул ажлын байрыг нөхөх, уг албан тушаалд иргэдийг нөөцөөс нэр дэвшүүлэх, Төрийн албаны салбар зөвлөлийг байгуулах, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулах, нарийн бичгийн даргыг томилуулах зэрэг асуудлаар Төрийн албаны зөвлөлд ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх боломжгүйг үүгээр мэдэгье. /	1		1
210	2016.09.22 №961	ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ж.БАТ-ЭРДЭНЭ	"Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" Засгийн газрын 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 03 дугаар тогтоолын дагуу "Ажлын байрны жагсаалт, орон тоог батлах тухай" Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 02 дугаар тушаалаар тус яамны ажлын байрны жагсаалт, орон тоо шинэчлэн батлагдсан байх бөгөөд дээрх тушаалын дагуу Н.Баттулгын эрхэлж байсан ажлын байр, чиг үүрэг Бодлого, төлөвлөлтийн газрын Стандарт, нормативын хэлтэст шилжсэн байна. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.3-т төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц нь өөрчлөгдсөн боловч төрийн албан хаагчийн албан тушаал (ажлын байр)-ын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол түүнийг уг албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах гэж заасны дагуу Н.Баттулгыг өмнө эрхэлж байсан ажил, албан тушаалд эгүүлэн томилж, төрийн жинхэнэ албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж ажиллана уу.	1		1

211	2016.10.03 №9999	УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ц.ЦОЛМОН	<p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 06 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын Тамгын газрын референтийн албан тушаалын ангилал зэрэглэлийг Ахлах түшмэл, АА-6 байхаар баталсан бөгөөд Б.Тогоодоржийн мэргэшлийн шалгалт өгсөн төрийн жинхэнэ албан тушаалын ангилал зэрэглэл нь Дэс түшмэл, ТЗ-7 байгаа нь Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан "Т" төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-ын нөөцөөс нэр дэвшүүлэх тухай "Зургаа"-ийн 6.3-т заасан "Нөөцөд байгаа иргэн мэргэшлийн шалгалт өгсөн төрийн жинхэнэ албан тушаалын зэрэглэлтэйгээ адил зэрэглэлийн төрийн жинхэнэ албаны өөр албан тушаалд томилогдон ажиллаж болно" гэсэнтэй нийцэхгүй байхаас гадна Б.Тогоодорж нь Судалгаа шинжилгээний хэлтсийн Эдийн засгийн салбарын судалгаа хариуцсан референтийн ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод тавигдсан ерөнхий шаардлагыг бүрэн хангахгүй байна. Иймд Б.Ууганжаргал, Б.Тогоодорж нарыг Төрийн албаны зөвлөлөөс нэр дэвшүүлэх боломжгүйг мэдэгдье.</p>	1		
212	2016.10.06 №1006	ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА З.МЭНДСАЙХАН	<p>Ж.Мөнхбаатарыг ажлаар хангах тухай Ж.Мөнхбаатарын өргөдлөөс үзэхэд төрийн жинхэнэ албан хаагчдаа өмнөх Засгийн газрын үеийн яамны хариуцаж байсан ажил, албан тушаалаас нь чөлөөлж, "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 3 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор албан хаагчдыг байршуулан томилохдоо төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын чиг үүрэг, хармуцаж байсан ажил, Сургалтын төрийн сангийн эзэл, түүнээс үүдэн гарах эрсдэл зэргийг судлан үзэлгүйгээр асуудалд хандсан байна.</p> <p>Иймээс Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Салбарын эдийн засгийн загварчлал, концесс хариуцсан ахлах мэргэжилтний ажлын байранд ажиллаж байсан Ж.Мөнхбаатарын маргаантай асуудлыг судлан үзэж, ажлаар хангах арга хэмжээ авна уу!</p>	1		
213	2016.10.20 №1054	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Р.СОДХҮҮ	<p>Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэчийн 2016 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн Б/36 дугаар тушаалаар С.Хүрэлтулгыг Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын албан тушаалаас чөлөөлж, 09 дүгээр сарын 14-ний өдрийн Б/46 дугаар тушаалаар түүнийг тус аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хяналтын улсын байцаагчаар албан тушаал бууруулан томилсон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2-т заасан ээлжийн амралттай байгаа үед ажил, албан тушаалыг хэвээр хадгална гэж заасныг зөрчсөн гэж үзэхээр байна.</p> <p>Учир нь С.Хүрэлтулга нь 2016 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс мөн оны 09 дүгээр сарын 27-ны өдрийг дуустал ээлжийн амралттай байсан нь холбогдох баримтуудаар нотлогдож байна.</p> <p>Иймд Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэчийн 2016 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн Б/36, Б/46 дугаар тушаалуудын С.Хүрэлтулгад холбогдох хэсгүүдийг хүчингүйд тооцож, дүнг Төрийн албаны зөвлөлд 2016 оны 11 дүгээр сарын 01-ний дотор ирүүлж, хариуг С.Хүрэлтулгад түүгээрээ өгөхийг мэдэгдье.</p>	1		

214	2016.10.25 №1075	ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ж.ГАНБААТАР	хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох ажилтан болж байх үйлдлийн гүйцэтгэл, ил тод байх, иргэд хүрээнд тухайн ажлын байрны тодорхойлолтын шаардлагыг боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлагын хувьд хангаж байгаа иргэнийг төрийн жинхэнэ албан хаагчаар томилуулахаар нэр дэвшүүлэх, уг хуулийн хэрэгжилтийг хангах үүргийг Төрийн албаны зөвлөлийн аймаг дахь салбар зөвлөл өөрөө хариуцах ёстой. Мөн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлд "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Тамгын газрын дарга нь тухайн Тамгын газрын ажилтнуудыг томилж, чөлөөлнө" гэж, Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлд захиргааны хууль бус актыг Захиргааны байгууллага өөрөө хүчингүй болгож шийдвэрлэхээр заасныг тус тус баримталж тухайн ажлын байрны шаардлагыг хангахгүй байгаа байдлыг бүрэн нотолсны үндсэн дээр томилгоо хийсэн шийдвэрийг Тамгын газрын дарга өөрөө хүчингүй болгож, Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах нь зүйтэй. Шийдвэрийг хүчингүй болгох хугацааг шийдвэр гаргах өдрөөр тасалбар болгохыг анхаарна уу	1	
215	2016.10.26 №1077	ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАЯРСАЙХАН	Д.Мөнхзаяагийн гомдолтой асуудлыг хууль тогтоомжийн дагуу ил тод, шударга, тэгш байдлын зарчмын дагуу шийдвэрлэн, хэрхэн шийдвэрлэсэн талаараа Төрийн албаны зөвлөлд албан ёсоор мэдэгдэнэ үү.	1	
216	2016.10.26 №1089	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Р.СОДХҮҮ	"Ажлаас чөлөөлөх тухай" Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2016 оны 08 дугаар сарын 26-ны Б/05 дугаар тушаалаар Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар /хуучин нэрээр/-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргаар ажиллаж байсан П.Энхмааг албан тушаалаас чөлөөлсөн нь Хөдөлмөрийн тухай хуулийн 35.1.2-т заасан эзлэлийн амралттай байгаа үед ажил, албан тушаалыг хэвээр хадгална гэж заасныг зөрчсөн гэж үзэхээр байна. Учир нь П.Энхмаа нь 2016 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс мөн оны 08 дугаар сарын 30-ны өдрийг дуустал эзлэлийн амралттай байсан нь холбогдох баримтуудаар нотлогдож байна. Иймд Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2016 оны 08 дугаар сарын 26-ны Б/05 дугаар тушаалын П.Энхмаад С.Хүрэлтулгад холбогдох хэсгүүдийг хүчингүйд тооцож, дүнг Төрийн албаны зөвлөлд 2016 оны 11 дүгээр сарын 05-ны дотор ирүүлж, П.Энхмаад түүгээрээ өгөхийг мэдэгдье.	1	
217	2016.11.14 1190	Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Дашцэрэн БАРИЛГА, ХОТ	Б.Биндэръяагийн тухай Төрийн жинхэнэ албан хаагчийн тогтвор суурьшил, Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6-д заасны дагуу мэргэжил мэргэшлээ дээшлүүлэн ажиллах зорилго зэргийг нь харгалзан үзэж Б.Биндэръяаг суралцах, ажиллах боломжоор хангаж ажиллах/	1	
218	2016.11.22 №1241	БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.МАГНАЙСҮРЭН	Б.Батхшигийн талаар Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд төрийн албан хаагч өөрийн хүсэлтээр суралцах, төрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх зэрэг баталгаагаар хангагдах хуулийн зохицуулалттай тул ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж ажиллана уу/	1	
219	2016.11.24 №1250	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр	Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх тухай /Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд зохих журмын дагуу хяналт тавьж, шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийг салбарынхаа хэмжээнд хангаж, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шүүхийн шийдвэрийн биелэлтийг хариуг өгөх/	1	

231	2017.01.02 №13	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр	Уруу мэлд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Зоригт нь 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн Б/216 дугаар тушаалыг батлан гаргахдаа Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны акт гаргах ажиллагааг хийсэн эсэх, мөн төрийн захиргааны албан хаагчийг хуулийн үндэслэл, шаардлагын дагуу чөлөөлсөн эсэх асуудлуудыг хууль эрх зүйн хүрээнд хянан тогтоож, хариуг 2017 оны 01 дүгээр сарын 10-ны дотор ирүүлэх	1	
232	2017.01.03 №17	Төрийн албаны зөвлөлийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн дарга Г.Нандинжаргал	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баатарцогт нь 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн Б/80 дугаар тушаалыг батлан гаргахдаа Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны акт гаргах ажиллагааг хийсэн эсэх, мөн төрийн захиргааны албан хаагчийг хуулийн үндэслэл, шаардлагын дагуу чөлөөлсөн эсэх асуудлуудыг хууль эрх зүйн хүрээнд хянан тогтоож, хариуг 2017 оны 01 дүгээр сарын 10-ны дотор ирүүлэх Дараах зөвлөмжийг Салбар зөвлөлийнхөө үйл ажиллагаанд баримталж ажиллах нь зүйтэй. Үүнд 1. Зарлагдаж байгаа нутгийн захиргааны байгууллагуудын төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байрны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын мэдээлэл, сул орон тоо гарсан хуулийн үндэслэл, шалтгааны талаарх үнэн зөв мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх, 2. Сонгон шалгаруулалтад оролцох сонирхолтой иргэдэд урьдчилсан шалгалттай холбогдох сургалтыг зохион байгуулах, заавар, зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах, 3. Сүүлийн хоёр жилийн хугацаанд нээлттэй сонгон шалгаруулалтаар нөхөгдөхгүй байгаа ажлын байруудын жагсаалтыг гаргаж тэдгээрийг хуулийн дагуу нөхөн хангах арга хэмжээг авах талаар тодорхой ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэх, 4. Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтаар нөхөгдөөгүй дэс түшмэлийн 7, туслах түшмэлийн 23, нийт 30 ажлын байруудыг хуулийн дагуу нөхөх арга хэмжээг нэн даруй зохион байгуулах, 5. Төрийн албаны зөвлөлд сул орон тооны захиалгыг ирүүлэхдээ сул орон тоо гарсан хуулийн үндэслэл, тайлбарыг танилцуулгын хамт ирүүлдэг байх, 6. Шалгалтын дүнг "Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар, батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан дүн гаргах зааврын дагуу гаргах, Энэхүү зөвлөмжийн гүйцэтгэлийг хангахад Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанаас мэргэшил, арга зүйн зөвлөгөөг авч ажиллахыг анхаарна уу. Дархан-Уул аймгийн Татварын хэлтсийн даргын албан тушаалд Ж.Баярт-Одыг дээрх хууль тогтоомж болон Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь хэсгийг зөрчиж томилсон байна.	1	
233	2017.01.09 №44	Өмнөговь аймаг дахь салбар зөвлөлийн дарга Ө.Баянмөнх	1		
234	2017.01.12 №51	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Л.ЗОРИГТ	Төрийн албаны зөвлөлийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн дарга Г.Нандинжаргал	1	

235	2017.01.17 №83	МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ж.ГАНБААТАР	1. Зарлагдаж байгаа нутгийн захиргааны байгууллагуудын төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байрны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын мэдээлэл, сул орон тоо гарсан хуулийн үндэслэл, шалтгааны талаарх үнэн зөв мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх, 2. Сонгон шалгаруулалтад оролцох сонирхолтой иргэдэд урьдчилан шалгалттай холбогдох сургалтыг зохион байгуулах, заавар, зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах, 3. Сүүлийн хоёр жилийн хугацаанд нээлттэй сонгон шалгаруулалтаар нөхөгдөхгүй байгаа ажлын байруудын жагсаалтыг гаргаж тэдгээрийг хуулийн дагуу нөхөн хангах арга хэмжээг авах талаар тодорхой ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэх, 4. Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтаар нөхөгдөөгүй ажлын байруудыг хуулийн дагуу нөхөх саналыг нэн даруй ирүүлэх, Энэхүү зөвлөмжийн гүйцэтгэлийг хангахад Төрийн албаны зөвлөлийн Ажлын албанаас мэргэшил, арга зүйн зөвлөгөөг авч ажиллахыг анхаарна уу. Сул орон тооны "Ажлын байрны тодорхойлолт"-ыг Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор баталсан "Ажлын байр (Албан тушаал)-ны тодорхойлолт боловсруулах заавар"-ыг зөрчиж боловсруулсан байх тул сонгон шалгаруулж, дүгнэлт гаргах боломжгүй байна. Иймд Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор баталсан "Ажлын байр (Албан тушаал)-ны тодорхойлолт боловсруулах заавар"-ын "Ажлын байранд тавигдах шаардлага" болох "Боловсрол", "Мэргэжил", "Мэргэшил" гэсэн хэсгүүдийг нэмж боловсруулан ирүүлнэ үү.	1		
236	2017.01.19 №83	ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Д.ЗОРИГТ	Тамгын газрын даргын, Гэр бүлийн хөгжлийн газрын даргын, Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан тушаалд нэр дэвшүүлж, дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн холбогдох материал /танилцуулга болон төрийн албан хаагчийн анкет дугуу бөглөсөн, шалгалт өгсөн материал, чөлөөлсөн тушаалууд байхгүй/-ууд дутуу байх тул сонгон шалгаруулж, дүгнэлт гаргах боломжгүй байна.	1		
237	2017.01.19 №85	ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА О.АЛТАНСҮХ	Шийдвэрийн биелэлтийг хангуулах тухай Завхан аймгийн Сантмаргаз сумын иргэн Т.Гантулгаас ирүүлсэн өргөдлийг судлан үзээд тус аймаг дахь Салбар зөвлөлийн 2015 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 41 дүгээр тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Сантмаргаз сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Батаад мэдэгдсэн боловч одоог хүртэл дээрх тогтоолын биелэлт хангагдаагүй байна.	1		
238	2017.01.19 №86	Төрийн албаны зөвлөлийн Завхан аймаг дахь салбар зөвлөлд	Иймд Завхан аймаг дахь салбар зөвлөлийн 2015 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 41 дүгээр тогтоолын биелэлтийг Салбар зөвлөлийнхөө эрх хэмжээний хүрээнд бүрэн хангуулж, хариуг Төрийн албаны зөвлөлд 2017 оны 02 дугаар сарын 05-ны дотор ирүүлнэ үү.	1		
239	2017.02.01 №146	ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА Л.ШАГДАРСҮРЭН	"Ц.Болор-Оюуны ажлаас чөлөөлөх тухай" аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар өөрийн хүсэлтийг нь үндэслэн Ц.Болор-Оюуныг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн байх тул маргаан үүсгэж хянан үзэх боломжгүйг мэдэгдэж байна.	1		
240	2017.02.01 №147	СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА З.ЭНХТӨР ТАНАА	Төрийн албаны тухай хуулийн Хуулийн 10.6, 15 дугаар зүйлийн 15.1.8 дахь заалтуудыг зөрчин ажиллаж байх тул Ш.Мандахнар, Э.Өлзийтогтох, И.Батсүх, О.Балжинням нарыг нарыг төрийн алба, Хурлын төлөөлөгчийн зөвхөн аль нэгээр нь дагнан ажиллуулах арга хэмжээг хууль нийцүүлэн авч Төрийн албаны зөвлөлд 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдэгдэнэ үү.	1		

241	2017.02.17 №197	МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХОВД АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Б.ГАНБОЛД	Иргэн Ч.Гогойжавын өргөдөлд дурдсан асуудлыг Салбар зөвлөлийн хуралдаанаар хянан шийдвэрлэхдээ "Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам"-д заасны дагуу маргаан хянан шалгах комисс томилоогүй шууд шийдвэрлэсэн байгаа нь Салбар зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 06 дугаар хуралдааны тэмдэглэл болон "Тайлбар хүргүүлэх тухай" 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 10 тоот албан бичгээр тус тус нотлогдож байна.	1		
242	2017.02.21 №205	БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА А.ГЫЛЫМХАН	Иймд Салбар зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцож хариуг Төрийн албаны зөвлөлд 2017 оны 03 дугаар сарын 10-ны дотор ирүүлэхийг мэдэгдье. Цаашид Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд Төрийн албаны тухай хууль болон холбогдох дүрэм, журмыг баримтлан ажиллахыг анхааруулж байна	1		
243	2017.04.14 №464	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэцгийг Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-д нийцүүлж, Монгол Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-д заасны дагуу сул орон тооны захиалгыг 2017 оны 03 дугаар сарын 10-ны дотор ирүүлэхийг шаардаж байна. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай /Нийслэлийн Чинглэцэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын үүрэгт ажилд эгүүлэн томилохоор гарсан Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 365 тоот шийдвэр Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 221/МА2016/0503 тоот магадлалыг хэрэгжүүлж, Н.Ариунааг ажлаар хангах талаар утс зөвлөлийн 2016 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 896 тоотоор Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын ерөнхий газарт мэдэгдсэн болно. Өнөөдрийг хүртэлх хугацаанд шүүхийн шийдвэр биелэгдээгүй, төрийн албан хаагчийн эрх ашиг зөрчигдөж байх тул холбогдох байгууллагад чиглэл өгч ажиллах	1		
244	2017.04.19 №482	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА НАРТ	Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 43-т "Төрийн албаны зөвлөл нь энэ журмыг хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангана" гэж заасан байдаг. Журамд заасны дагуу төрийн байгууллагын зохихон байгуулалтын бүтцийн нэгжийн төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул ажлын байранд 2-оос доошгүй хүнийг сонгон шалгаруулж дүгнэлт гаргахдаа баримтлах	1		
245	2017.05.10 №596	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ц.ДАШЦЭРЭН	Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын 1 дүгээр багийн иргэн Н.Мэндбаяраас тус аймаг дахь Салбар зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 06 дугаар тогтоолын "...Бөмбөгөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан тушаалын нөөцөд бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн" хэсгийг эс зөвшөөрч гаргасан өргөдлийг үндэслэлтэй эсхийг шалгахад төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар Маргаан хянан шалгах комисс томилон ажиллуулаад байна. Иймд дээрх маргааныг Төрийн албаны зөвлөлөөр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл хугацаанд Захиргааны ерөнхий хуулийн 96 дугаар зүйлийн 96.1-д заасны дагуу Салбар зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 06 дугаар тогтоолын "...Бөмбөгөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан тушаалын нөөцөд иргэн Г.Магнайбаярыг бүртгэж, уг албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн" хэсгийн биелэлтийг түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдье.			1

246	2017.05.10 №601	ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Л.ЛХАМСҮРЭН	Удирдах албан тушаалд томилогдох ажилтныг батлагдсан "Төрийн жинхэнэ албаны Ерөнхий менежер буюу Төсвийн шууд захирагч"-ийн албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд заавал нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, уг орон тоог нөхөх эрх зүйн зохицуулалттай. Иймд Завхан аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл Алдархаан сумын Засаг даргад хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг шаардаж, сул орон тооны захиалгыг авч, Монгол Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-д заасны дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулна уу.	1		
247	2017.05.10 №602	ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Л.ЛХАМСҮРЭН	"Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ыг Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан. Энэхүү журмын 7 дугаар зүйлийн 7.5, 8 дугаар зүйлийн 8.1.3-т зааснаар төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдол бүрт сонгон шалгаруулалтыг шинээр зохион байгуулах бөгөөд сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэг иргэний нэрийг дэвшүүлж, дүгнэлтийн хамт томилох эрх бүхий этгээдэд хүргүүлэхээр журамласан байна. Иймд төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалын нөөцөд бүртгэж, өөр албан тушаалд нэр дэвшүүлэх тухай зохицуулалт байхгүй болно.	1		
248	2017.05.11 №631	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Н.НОМТОЙБАЯР	Төрийн албаны тухай хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж О.Балжиннямыг Сүхбаатар аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын албан тушаалд томилсон шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүйд тооцож төрийн албан хаагчдын эрх ашиг, нийгмийн баталгааг хангаж ажиллах	1		
249	2017.05.17 №650	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЕРБОЛАТ	Төрийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог хуулийн дагуу нөхөх, хууль зөрчсөн томилоо шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4-т заасан "иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адила тэгш боломжтой байх" зарчмыг хатуу баримтлан ажиллах	1		
250	2017.06.05 №717	Сүхбаатар аймгийн засаг дарга З.Энхтөр	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай.	1		
251	2017.06.07 №741	Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөлийн дарга Д.Содном	Салбар зөвлөлийн үйл ажиллагаа аливаа байгууллага албан тушаалтнаас хараат бус бие даасан байх болон хамтын удирдлагын зарчим хэрэгжихгүй байгаа талаар	1		
252	2017.06.08 №745	Дорнод аймгийн Халхгол сумын Нөмрөгийн дархан цавээт газрын хамгаалалтын захиргааны газрын дарга Г.Батболд	"Дүгнэлт гаргах тухай" Төрийн албаны зөвлөлийн Дорнод аймаг дахь салбар зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 10 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх	1		
253	2017.06.09 №752	Цөмийн энергийн комиссын Ажлын албаны дарга Г.Манлайжав	Ерөнхий менежер буюу Төсвийн шууд захирагчийн албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд заавал нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, уг орон тоог нөхөх тухай			1
254	2017.06.09 №753	БОАЖЯ-ны ТНБДарга Ц.Цэнгэл	Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын даргын албан тушаалд нэр дэвшигч С.Бат-Эрдэнэ нь "Ажлын байрны тодорхойлолт"-д тавигдсан мэргэжлийн шаардлага хангахгүй, яамны газрын дарга гэхэд ажилласан жилийн шаардлага хэт бага байх тул дүгнэлт гаргах боломжгүй байна			1
255	2017.06.12 №755	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга О.Алтансүх	Тамгын газрын албан тушаалд нэр дэвшигч Ш.Чинбат нь 2012 онд өөрийн хүсэлтээр төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн, Гэр бүл хөгжлийн газрын даргын албан тушаалд нэр дэвшигч Н.Өлзийхутаг нь 2009 онд өөрийн хүсэлтээр төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн байх тул нэр дэвшигч нарт дүгнэлт гаргах боломжгүй байна.			1

256	2017.06.21 №804	Ховд аймгийн засаг дарга Н.Цагаанхүү	Хууль тогтоомж хэрэгжүүлэх тухай /Говь-Алтай аймгийн мэргэжлийн хяналтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Түмэнбаатарыг албан тушаалаас нь чөлөөлж, 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн дотор хариу ирүүлэх/	1	
257	2017.06.27 №813	Булган аймгийн Бугат сумын Тамгын газрын дарга Г.Лхагважаргал	Хууль тогтоомж хэрэгжүүлэх тухай /С.Бямбыг албан тушаалаас чөлөөлж, 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор хариу ирүүлэх/	1	
258	2017.06.27 №816	Сүхбаатар аймаг дахь салбар зөвлөлд	Хууль тогтоомж хэрэгжүүлэх тухай /Сонгон шалгаруулалтад ороогүй, төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэгдээгүй хүнийг Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж томилгоо хийсэн бол хуульд нийцүүлэх арга хэмжээг авч, Төрийн албаны зөвлөлд 2017 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор мэдэгдэх/	1	
259	2017.06.29 №827	Говь-Алтай аймгийн засаг дарга С.Гансэлэм	Хууль тогтоомж хэрэгжүүлэх тухай /Б.Баян-Эрдэнийг албан тушаалаас чөлөөлж, 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн дотор хариу ирүүлэх/	1	
260	2017.06.29 №829	Төрийн албаны зөвлөлийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлийн дарга Г.Өнөрбаяр	Шийдвэр хүчингүй болгох тухай /Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлог гүйцэтгэгчийн 2016 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн Б/64 дүгээр тушаалыг хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэн салбар зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 25 дугаар тогтоолыг хүчингүйд тооцож, хариуг 2017 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэх	1	
261	2017.06.29 №836	Сүхбаатар аймаг дахь салбар зөвлөлийн дарга Ч.Энхцэцэг	Төрийн захиргааны албан тушаалд төрийн албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалт өгөөгүй иргэнийг түр хугацаагаар болох шууд томилох боломжгүй тул хууль бусаар томилогдсон иргэдийг уг албан тушаалаас нь чөлөөлж, хууль тогтоомжийн хүрээнд сул ажлын байрыг нөхөх үүргийг төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудад өгч, зөрчлийг нэн даруй арилгуулах нь зүйтэй. Аймаг дахь салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль түүнтэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэхэд нутгийн захиргааны төрийн байгууллагуудыг арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих, гарсан зөрчлийг арилгуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд төрийн алба, албан хаагчийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг судалж, Салбар зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байгааг үүгээр анхааруулж байна	1	
262	2017.07.04 №852	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбат	Танай байгууллагаас ирүүлсэн албан бичигт материал дугуу, нэр дэвшигчид "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "а", "б"-д заасан шалгуурыг хангахгүй байх тул сонгон шалгаруулж, дүгнэлт гаргах боломжгүй байна.	1	
263	2017.07.06 №875	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр	Хууль тогтоомж хэрэгжүүлэх тухай /М.Мянганбууг Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн албан тушаалаас чөлөөлж, 2017 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн дотор хариу ирүүлэх	1	
264	2017.07.27 №914	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригт	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Б/235 дугаар тушаалыг хүчингүйд тооцох, мөн С.Отгоныг өмнө ажиллаж байсан ажил, албан тушаалтай адилтгах албан тушаалд томилох асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэж, төрийн жинхэнэ албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж ажиллах, цаашид хүний нөөцийн үйл ажиллагаанд Төрийн албаны тухай хууль болон холбогдох дүрэм журмыг чанд баримтлан ажиллахыг анхааруулж байна.	1	
265	2017.08.15 №945	Ховд аймгийн засаг дарга Д.Галсандондог	Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай /Ховд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчөөр ажиллаж байгаа Төмөрбаатарын Баатарзоригийг тус аймгийн засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Б/109 дүгээр захирамжаар аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон нь Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6, 15 дугаар зүйлийн 15.1.8-д заасныг тус тус зөрчиж байна. Иймд дээрх зөрчлийг арилгах арга хэмжээг авч, хариуг яаралтай ирүүлэх	1	

266	2017.08.22 №961	БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНХУУ	Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-ын Нөөцийн санд хандаж захиалга ирүүлэх тухай 5.3.2-т зааснаар тухайн сул орон тоо гарсныг нотлох шийдвэр дутуу байх тул Б.Мөнхбаярыг энэ удаа нэр дэвшүүлэх боломжгүй байна			1
267	2017.08.23 №973	НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Л.ЭРДЭНЭЧУЛУУН	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн Б/415 дугаар тушаалыг хүчингүйд тооцох, Монгол улсын шүүхийн шийдвэрийн дагуу биелэлтийг хангаж Г.Мөнхтуяаг өмнө эрхэлж байсан ажил, албан тушаалд эгүүлэн томилж хууль дээдлэх зарчмыг баримталж ажиллах			1
268	2017.09.06 №1009	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ч.ЭНХЦЭЦЭГ	Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгч Т.Мөнхтулга нь аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргаар, М.Төмөрчулуун нь Санхүү төрийн сангийн хэлтсийн даргаар, Ц.Хүрэлбаатар нь Эрүүл мэндийн газарт мэргэжилтнээр тус тус томилогдон ажиллаж байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6, 15.1.8-д зааныг тус тус зөрчиж байна. Иймд төрийн улс төрийн албан хаагчийг төрийн жинхэнэ албан тушаалд томилсон зөрчлийг хуулийн хүрээнд нэн даруй арилгаж, хариуг Төрийн албаны зөвлөлд 2017 оны 09 дүгээр сарын 15-ны дотор ирүүлэх			1
269	2017.09.12 №1029	ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ч.САРАНГЭРЭЛ	Тус аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дарга нь сонгон шалгаруулалтаар томилогдоогүй, түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон байх тул албан бичигт дурдсан сургууль, цэцэрлэгийн захирлын сонгон шалгаруулалтын комисс томилох, зохион байгуулах чадамжгүй юм. Иймд Боловсрол, соёл урлагийн газрын даргын ажлын байрыг хууль тогтоомжинд заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, уг орон тоог нөхөх ажлыг яаралтай зохион байгуулна уу.			1
270	2017.09.12 №1031	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХОВД АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Б.ГАНБОЛД	Иргэн Я.Азбилэг нь Ховд аймаг дахь Салбар зөвлөлөөс 2017 оны 06 сарын 05-09-ний өдрүүдэд зохион байгуулагдсан төрийн жинхэнэ албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтад оролцож, тухайн өрсөлдсөн ажлын байран дээр хамгийн өндөр оноог авсан байх бөгөөд түүнийг Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 129 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын Санхүү төрийн сангийн хэлтсийн орлого, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн байна. Иймд Төрийн албаны тухай хууль болон Төрийн албаны зөвлөлийн тогтоолын биелэлтийг хуулийн хүрээнд хангаж, иргэн Я.Азбилэгийг тухайн албан тушаалд томилж хариуг 2017 оны 09 дүгээр сарын 30-ны дотор ирүүлэх			1
271	2017.09.18 №1033	МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛҮҮДЭД	Монгол Улсын Их Хурлын нөмрөн ээлжит бус чуулганы 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын ерөнхий сайд болон Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулах шийдвэр гаргасан билээ. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд бүх шатны төрийн байгууллагын хүний нөөцийн бодлогыг зохион байгуулах, төрийн албан хаагчдыг тогтвортой ажиллуулах зарчмыг хэрэгжүүлэхэд мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй. Иймд Засгийн газрыг шинэчлэн байгуулагдах хүртэл хугацаанд бүх шатны төрийн захиргааны байгууллагын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийлгэхгүй байх арга хэмжээ авахыг зэрэгцээ төрийн албан хаагчдыг томилох, чөлөөлөх, халах, сэлгэх, шилжүүлэх зэрэг хүний нөөцтэй холбоотой шийдвэр гаргахгүй байх талаар эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг чиглэл өгч, төрийн ажил үйлчилгээг хэвийн шуурхай явуулж, хариуцлага, үр дүнг хангаж ажиллахыг үүрэг болгож байна.			1

272	2017.09.22 №1048	БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ГАН-ЭРДЭНЭ	Увс аймгийн 21-ийн улсын их аурдлын намрын ээлжит оус чуулганы 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайд болон Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулах шийдвэр гаргасан билээ. Үүнтэй холбогдуулан төрийн албаны хүний нөөцтэй холбоотой шийдвэр гаргахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах үүрэг чиглэлийг Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 1033 тоотор өмнө нь хүргүүлсэн билээ. Засгийн газрыг шинэчлэн байгуулагдаж, танай яамны Төрийн нарийн бичгийн даргын томилгооны асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэгдэх хүртэл хугацаанд Төрийн албаны зөвлөлийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэргэдэх салбар зөвлөлөөс төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, дүгнэлт гаргах зэрэг Салбар зөвлөлийн чиг үүрэгт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргахгүй байх нь зүйтэй. Яамны болон харьяа бүх шатны төрийн байгууллагуудын удирдах, гүйцэтгэх албан хаагчдыг томилох, чөлөөлөх, халах, сэлгэх, шилжүүлэх зэрэг хүний нөөцийн хөдөлгөөн мөн хийхгүй байхыг дахин анхааруулж байна.	1		
273	2017.09.26 №1067	ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ж.БАТ-ЭРДЭНЭ	Ганхүүгийн Ундрах нь Дэс түшмэлийн ангилал, ТЗ-7 зэрэглэлийн ажлын байранд шалгалт өгч тэнцсэн боловч Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-ын "Нөөцөөс нэр дэвшүүлэх" тухай зургаа дахь хэсгийн 6.3-т заасантай зөрчилдөж байх тул яамны ахлах мэргэжилтэн/Ахлах түшмэл, ТЗ-8/-ий ажлын байранд нэр дэвшүүлэх боломжгүй байна.	1		
274	2017.09.27 №1069	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.МАГНАЙСҮРЭН	Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-ын "Нөөцийн санд хандаж захиалга ирүүлэх тухай" тав дахь хэсгийн 5.3.2-т зааснаар дээрх ажлын байрны сул орон тоо гарсныг нотлох баримт дутуу байх тул Баярдалайн Анх-Оргилыг нэр дэвшүүлэх боломжгүй мэдэгдье	1		
275	2017.10.02 №1092	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН УВС АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН С.БАТЖАРГАЛ	Увс аймгийн Өмнөговь сумын иргэн Д.Цэгмэдээс "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэх, нэр дэвшүүлэх тухай" Төрийн албаны зөвлөлийн Увс аймаг дахь Салбар зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг эс зөвшөөрч гаргасан маргааныг хянан шалгасан Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг үүгээр хүргүүлж байна. Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг үүгээр мэдэгдье.	1		
276	2017.10.04 №1102	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ж.МӨНХБАТ	Ж.Болормаг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилсон Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 291 дүгээр тогтоолыг хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээг авна уу.	1		
277	2017.10.06 №1111	СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ГАЗРЫН ДАРГА З.ТҮВШИНТӨГС	"Н.Болдмааг ажилд томилох тухай" Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн Б/15 дугаар тушаалыг хүчингүй болгож, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 17.5-д заасны дагуу Хүрээлэн буй орчны бохирдол, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, химийн бодисын асуудал хариуцсан мэргэжилтэн, Аялал жуулчлал, төрийн бус байгууллагын асуудал хариуцсан мэргэжилтний сул ажлын байруудын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлд 2017 оны 10 дугаар сарын 30-ны дотор хүргүүлэн нээлттэй сонгон шалгаруулалт явуулж уг ажлын байрыг нөхөх нь зүйтэй.	1		
278	2017.10.06 №1113	БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ДЭЛҮҮН СУМЫН ЗАСАГ ДАРГА А.МУСАХАН	"Ажилд томилох тухай" Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын Засаг даргын 2017 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн Б/01 дүгээр тушаалыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд хүчингүй болгож, тус сумын байгаль орчны хяналтын улсын байгаагчийн ажлын байрыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу нөхөх арга хэмжээг авч, хариуг иргэн Х.Баделд түүгээрээ өгч, дүнг Төрийн албаны зөвлөлд 2017 оны 10 дугаар сарын 30-ны дотор ирүүлэх	1		

279	2017.10.09 №1122	ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Д.ЗОРИГТ	Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 04 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-ын "Хоёр" дугаар бүлгийн 2.2.4-д "Нөхөр (эхнэр) нь эрх бүхий байгууллагын томилолтоор өөр нутаг дэвсгэрийн нэгжид, мөн гадаад улс, олон улсын байгууллагад шилжин ажиллах болсон, эсхүл хүнд өвчтэй гэр бүлийн аль нэг гишүүнээ асрах зайлшгүй шаардлагын улмаас Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-т заасны дагуу өөрийн санаачилгаар төрийн албанаас чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчийн нөөц" байна гэж заасан. Иймд журмын 2.2.4-д заасан үндэслэлээр төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд байх үндэслэлээр түр чөлөөлөгдсөн Д.Дэлгэрцэцгийг ажлын байраар хангах арга хэмжээ авна уу.	1	
280	2017.09.12 №1028	БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НОГООННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ	А.Калемшарт хариуцлага тооцож, сул орон тооны захиалгаа аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд ирүүлэх	1	
281	2017.10.11 №1131	СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА Г.ГАНТӨМӨР	Ахлах мэргэжилтэн Д.Дамбасүрэнг Хэмжил зүйн хүрээлэнгийн даргын үүргийг түр орон гүйцэтгэгчээр томилсон нь Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлд нийцэж байгаа боловч, томилсон өдрөөс хойш 8 сар өнгөрсөн байхад Монгол Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-т заасны дагуу сонгон шалгаруулж, дүгнэлт гаргуулаагүй байна. Иймд "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-д заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын Хэмжил зүйн хүрээлэнгийн даргын ажлын байрны сул орон тоонд томилогдох ажилтныг сонгон шалгаруулж, дүгнэлт гаргуулах албан захиалга, холбогдох материалаа Төрийн албаны зөвлөлд 2017 оны 10 дугаар сарын 20-ны дотор ирүүлж, уг томилооны асуудлыг хуульд нийцүүлэн эцэслэн шийдвэрлэх "Хошууч генерал З.Болдбаатарыг чөлөөлөх тухай" Батлан хамгаалахын сайдын 2017 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн Б/32 дугаар тушаалаар Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн албан тушаалаас чөлөөлж, яамны төрийн захиргааны удирдлагын газрын мэдэлд шилжүүлж, мөн өдрийн Б/54 дүгээр тушаалаар элжийн амралт эдлүүлэх тухай тушаал гаргажээ. Өргөдөлд дурдсанаас үзвэл З.Болдбаатарыг элжийн амралтын хугацаа нь дууссан боловч өнөөдрийг хүртэл ажилд томилоогүй байна. Төрийн жинхэнэ албан хаагч, хошууч генерал З.Болдбаатарыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажилд томилох тухай асуудлыг шийдвэрлэх	1	
282	2017.10.13 №1151	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАТ-ЭРДЭНЭ	Мягмарсүрэнгийн Балдорж нь 2017 оны 04 дүгээр сард Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлөөс зохион байгуулсан Нийслэлийн Хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөөний газрын Хотын хэмжээнд сэргээгдэх эрчим хүчийг ашиглах судалгаа, тооцоо, төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байранд шалгалт өгч, өрсөлдсөн албан тушаалдаа хамгийн өндөр оноо авсан тул уг албан тушаалд нь томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарсан байна. Хэрэв Мягмарсүрэнгийн Балдорж нь өрсөлдсөн албан тушаалдаа томилогдохоос татгалзвал уг шалгалтын дүнг хүчингүйд тооцох журамтай. Иймд танай байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд нэр дэвшүүлэх боломжийг мэдэгдье.	1	
283	2017.10.13 №1156	ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА З.МЭНДСАЙХАН	Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн Б/13 дугаар тушаалаар Б.Нарангэрэлийг үүрэгт ажлаас чөлөөлж, Гаалийн ерөнхий газрын мэдэлд шилжүүлсэн боловч өнөөдрийг хүртэл ажилд томилоогүй байна. Иймд Б.Нарангэрэлийг ажилд томилох тухай асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд яаралтай шийдвэрлэж, энэ тухайгаа Төрийн албаны зөвлөлд мэдэгдэнэ үү.	1	
284	2017.10.23 №1177	ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Б.АСРАЛТ			

285	2017.11.02 №1209	БААИ АЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ц.ЦЭНГЭЛ	Эрдэнэ нь "Ажлын байрны тодорхойлолт"-д тавигдсан мэргэжлийн шаардлага хангахгүй, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад орж байгаагүй, "Ажлын байрны тодорхойлолт"-од тавигдсан ажилласан жилийн шалгуур яамны газрын дарга гэхэд хэт бага байх тул Төрийн албаны зөвлөлөөс уг албан тушаалд нэр дэвшигчид дүгнэлт гаргах боломжгүй байна.			1
286	2017.11.02 №1211	ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА Б.БАЯРСАЙХАН	Албан тушаалд нэр дэвшүүлж ирүүлсэн албан хаагчдын анкет байхгүй, "Ажлын байрны тодорхойлолт"-д тавигдсан ажилласан жилийн шалгуур агентлагийн хэлтсийн дарга гэхэд хэт бага, Нанзадын Баярчимэгийг мэргэжилтний албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн нэр дэвшүүлсэн шийдвэргүйгээр шууд томилсон байх тул сонгон шалгаруулж, дүгнэлт гаргах боломжгүй байна.			1
287	2017.11.02 №1213	ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.БАТЛУТ	Аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Б/30 дугаар захирамж нь "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 4.2.1 дэх заалтыг зөрчсөн байх тул хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, өргөдөл гаргасан албан хаагчдад хариу өгч, Төрийн албаны зөвлөлд мэдэгдэнэ үү.	1		
288	2017.11.02 №1214	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Т.ЖАМБААЖАМЦ	Албан тушаалд нэр дэвшүүлж ирүүлсэн албан хаагчдын танилцуулгад дурдсан шалгуур "Ажлын байрны тодорхойлолт"-од тавигдсан шалгуураас өөр, Батаагийн Лхагвасүрэн, Сандуйжавын Баянцогт нарын төрийн албаны шалгалт өгсөн тухай мэдээлэл байхгүй, баримт материалыг хангалтгүй бүрдүүлсэн байх тул сонгон шалгаруулж, дүгнэлт гаргах боломжгүй байна.			1
289	2017.11.13 №1250	ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА Б.ЧИНБАТ	2016 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн "Гадаад улсад урт хугацаагаар суралцуулах тухай гэрээ" болон "Албан тушаалаас нь чөлөөлөх, урт хугацааны сургалтад хамруулах тухай" Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын 2016 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн Б/30 дугаар тушаалаас үзвэл Б.Эрдэнийг сургалтаа амжилттай төгсч ирсэн тохиолдолд ажлын байраар хангах үүргийг ажил олгогч хүлээсэн байна. Иймд Б.Эрдэнийг "Гадаад улсад урт хугацаагаар суралцуулах тухай гэрээ"-ний 4.5 дахь хэсэгт заасны дагуу ажлын байраар хангаж, томилсон тухайгаа Төрийн албаны зөвлөлд албан бичгээр мэдэгдэнэ үү.	1		
290	2017.11.13 №1253	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЗАНДАНБАТ	"Албан тушаалаас чөлөөлж, мэдэлд шилжүүлэх тухай" Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Занданбатын 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн Б/263 дугаар тушаал нь Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.3 дахь заалт "захиргааны актыг гаргах бодит нөхцөл байдал, хууль зүйн үндэслэлийг заах" гэснийг зөрчсөн байна. Иймд "Албан тушаалаас чөлөөлж, мэдэлд шилжүүлэх тухай" 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн Б/263 дугаар тушаалыг хүчингүй болгож, шийдвэрийг Төрийн албаны зөвлөлд 2017 оны 11 дүгээр сарын 20-ны дотор ирүүлнэ үү.	1		
291	2017.11.17 №1270	МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Н.ЦАГААНХҮҮ	Б.Түмэнбаатарыг Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр төрийн албаны тухай хууль тогтоомжийг зөрчиж томилсон шийдвэрийг хүчингүй болгож, сул орон тоог нөхөх тухай захиалгаа Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлд ирүүлж, Төрийн албаны зөвлөлд 2017 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ үү. Дурдсан хугацаанд шийдвэрлээгүй тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5-д заасан эрхийнхээ хүрээнд Төрийн албаны зөвлөл шийдвэрлэх болно гэдгийг мэдэгдье.	1		
292	2017.11.17 №1271	ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД С.ЧИНЗОРИГ	М.Мянганбууг Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр төрийн албаны тухай хууль тогтоомжийг зөрчиж томилсон шийдвэрийг хүчингүй болгож, сул орон тоог нөхөх тухай захиалгаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлд өгч, Төрийн албаны зөвлөлд 2017 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдэгдэнэ үү. Дурдсан хугацаанд шийдвэрлээгүй тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5-д заасан эрхийнхээ хүрээнд Төрийн албаны зөвлөл шийдвэрлэх болно гэдгийг мэдэгдье.	1		

293	2017.11.23 №1299	ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Д.ЗОРИГТ	Хууль тогтоомж хэрэгжүүлэх / Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газрын даргын албан тушаалд томилодох ажилтны нээлттэй сонгон шалгаруулалтыг 2017 оны 12 дугаар сард багтаан зохион байгуулж, хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг анхааруулж байна.	1	
294	2017.11.29 №1311	Говь-Алтай аймгийн засаг дарга С.Гансэлэм	Төрийн албаны тухай хуулийн 15.1.8 дахь заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг зөрчин ажиллаж байгаа Б.Баян-Эрдэнийг төрийн алба, Хурлын төлөөлөгчийн хуульд нийцүүлж зөвхөн аль нэгээр нь дагнан ажиллуулах арга хэмжээг авсан талаар Төрийн албаны зөвлөлд 2017 оны 12 дүгээр сарын 05-ны өдрийн дотор мэдэгдэнэ үү	1	
295	2017.12.04 №1347	ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Д.СОДНОМ	Төрийн албан хаагчийн тэтгэвэртэй холбоотой асуудлыг төрийн албаны тухай хууль, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар тус тус зохицуулсан байдаг. Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчийг дараахь үндэслэлээр төрийн албанаас чөлөөлнө", 24.1.1 дэх заалтад "тэтгэвэр тогтоолох насанд хүрсэн", 24.1.2 дахь заалтад "төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн", Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэгт цэргийн тэтгэвэр тогтоолсон дээд офицер, офицер, ахлагчийг эзэмшсэн мэргэжлийнх нь чиглэлээр төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэлтэйд тооцож, төрийн байгууллагад энгийн албан тушаалд томилон ажиллуулж болно, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт "Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 55 нас хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно", Хөдөлмөрийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1 дэх хэсэгт "тэтгэвэр авагч ахмад настан хөдөлмөр эрхэлж болно" гэж тус тус заасан байна. Дээрх хуулиудад зааснаас үзвэл, төрийн захиргааны албан хаагч тэтгэвэр тогтоолох насанд хүрч, төрийн албанаас чөлөөлөгдсөн бол дахин төрийн жинхэнэ албан тушаалд томилогдон ажиллах боломжгүй, харин төрийн үйлчилгээний албан тушаалд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилогдон ажиллаж болно. Цэргийн тэтгэвэр тогтоолсон дээд офицер, ахлагч, төрийн үйлчилгээний албан хаагчаар ажиллаж байгаад тэтгэвэр тогтоолсон иргэн Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтад заасан тэтгэвэр тогтоолох насанд хүрээгүй буюу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан насанд хүрээгүй бол төрийн захиргааны албан тушаалд томилогдон ажиллаж болох бөгөөд төрийн үйлчилгээний албан тушаалд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилогдон ажиллаж болно. Хууль тогтоомжид заасны дагуу төрийн албанаас тэтгэвэрт гарахад олгогддог нэг удаагийн бэлтгэл үзэмжгүйг нэг удаа олгох боломжгүйг анхааруулж байна.	1	
